



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2021.01.28 №04 (10733)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн ахмад Д.МЭНДБАЯР

Х.Баттулга: УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГҮҮДИЙГ ШИНЭЧЛЭН МӨРДӨХ НЬ ТА БҮХНИЙ ҮҮРЭГ



Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалт энэ өдрүүдэд явагдаж байна. Цугларалтын нээлтэд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга, Батлан хамгаалахын сайдын үүрэг гүйцэтгэгч, бригадын генерал Г.Сайханбаяр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан

хамгаалахын бодлогын зөвлөх Л.Болд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг нар оролцлоо. Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулгын хэлсэн үгийг бүрэн эхээр нь хүргэж байна.

(Үргэлжлэл нь II нүүрт)

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН НЭГЖҮҮДЭД ҮҮРЭГ ЧИГЛЭЛ ӨГЛӨӨ



БХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас "Байгууллагын дотоод хяналтыг зохион байгуулах, үр нөлөөг дээшлүүлэх" сэдэвт цахим сургалтыг энэ сарын 18-19-нд Сангийн яам, Авилгатай тэмцэх газар, Дотоод аудитын институттай хамтран дотоод хяналт, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, санхүүгийн хяналт шалгалт, сахилга зохион байгуулалт, Зэвсэгт хүчний удирдах албан

тушаалтны ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээний үргэлжлэл болгон сайд Г.Сайханбаяр Батлан хамгаалахын болон Зэвсэгт хүчний хяналт шалгалтын нэгжүүдтэй "Батлан хамгаалах нэгдмэл хяналт" сэдэвт уулзалтыг энэ сарын 21-нд зохион байгууллаа.

Уулзалтыг нээж Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар үг хэлсний дараагаар БХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ,

дотоод аудитын газрын дарга, хурандаа Б.Эрхэмбаяр, Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргыг түр орлон гүйцэтгэгч, хурандаа Д.Ариунболд, Зэвсэгт хүчний Авто техникийн хяналтын албаны дарга, хурандаа Л.Баярцогт нар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний хэмжээнд хяналт шалгалтын нэгжүүдийн хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар товч танилцуулав.

(Үргэлжлэл нь V нүүрт)

ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

Б.Арслан: МЯНГАН АГТЫГ САР ГАРУЙН ХУГАЦААНД ТУУСААР МАНЖУУРТ ХҮРГЭЖ БАЙЛАА

Энэ онд Батлан хамгаалах яамны 110, Зэвсэгт хүчний 100 зэрэг тэгш ойг тэмдэглэн өнгөрүүлэх юм. Мэдээж эдгээр үйл явдлын гэрч, гол эзэд нь бэлтгэл, чөлөөндөө гарсан буурлууд байх учиртай. Эгэл малчны хотонд төрж, хожмоо эрхэм хурандаа гэж дуудуулах болсон Б.Арслангийн намтар, түүх сонин юм. Тэрээр үг хурц, чих соргог гэж жигтэйхэн. "Хүн явсан мөрөө эргэж хардаг. Миний алхсан замаар үр минь ч туучиж болох хорвоо шүү дээ. Хар мөртэй үлдчихгүй юм сан гэсэндээ аль болох хүний өөрийн гэлтгүй хэнийг ч чадахаараа дэмнэж, сэтгэл рүү нь ус цацчихгүйхэн шиг явж ирсэн дээ. Тус дэм болсноо тэглээ, ингэлээ гээд хүнд нэг их яриад байдаггүй" гээд даруухан загнах нь бүр ч хэвлүүхэн юм даа.

Та сайхан өвөлжиж байна уу? Зэвсэгт хүчний архив болсон тан шиг хүнтэй тэр бүр уулзалдаад байж чадахгүй юм даа ...

-Би 1930 онд Сүхбаатар аймгийн Түвшинширээ буоу хуучнаар Өлзийт сумын нутагт төрсөн хүн. Эхээс наймуул. Одоогоор би л үлдэж, бусад нь бурханы оронд заларсан. Намайг бага байхад тус сум татан буугдаж зарим баг нь Хэнтий аймгийн Баянхутаг суманд шилжсэн юм. Ингэснээр би Хэнтий аймгийн Баянхутаг сумын харьяат болсон. Ингээд Хэнтий аймгийн Өндөрхааны бага сургуулийг дүүргэснийхээ дараа 1945 онд үргэлжлүүлэн тухайн үеийн жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Офицерын сургуульд элслээ. Одоогийнхоор ҮБХИС-ийн харьяа Тэмүжин-Өрлөг сургууль юм. Офицерын сургуульд сурч байхдаа 18 нас хүрсэн жилдээ цэргийн тангараг өргөж байлаа. Харин 1951 онд 10 жилээ дүүргэхдээ цэргийн бага мэргэжил эзэмшсэн байв. Ингэж л цэргийн мэргэжлийн хүн болох шангаа татсан. Дараа нь ЦЕДС-ийн артиллерийн ангид их бууны мэргэжлээр хоёр жил суралцаад 1953 онд төгсөж офицерын анхны цолоо зүүсэн. Тэр цагаас хойш 1989 он хүртэл Зэвсэгт хүчний анги, салбаруудад тасралтгүй ажилласан.

1966 онд ЗХУ-ын Ленинград хотын Артиллерийн академид суралцахаар шалгалт өгч тэнцээд 1971 онд төгсөж байлаа. Төгсөөд иртэл тухайн үеийн Батлан

хамгаалахын яамны сайд, армийн генерал Б.Доржийн тушаалаар одоогийн Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн захирагчаар томилогдож 1975 он хүртэл ажилласан. Намайг ирэхээс урьтаж тийм санал гарсан юм байна лээ. Эдгээр он жилүүд их хариуцлагатай цаг үе байсан гэж боддог. Салааны захирагч, штабын туслахаар ажиллаж байсантай харьцуулахад хавьгүй олон хүнийг хариуцаж, илүү том бүтэцтэй байгууллагыг мэдэх болсонтой холбоотой. Ангийн хашаанаас гарч ажилласан үе ч бас бий. 1975-1977 он хүртэл ЗХЕШ-ын нэгдүгээр хэлтсийн Сургалт, соёл хүмүүжлийн асуудал эрхэлсэн офицероор ажилласан. Тухайн үед хурандаа н.Товод гэж хүн намайг хариуцаж, тэр даргын буянаар чамгүй зүйлд дадсандаа баярладаг.

Нэгдүгээр мотоуудлагын тусгай бригад гэж байв. Хүйтэн дайны жилүүдэд дивиз болж өргөтгөн зохион байгуулагдсан. Тус дивизэд 1977-1982 он хүртэл Артиллерийн дарга, 1982-1987 он хүртэл Ерөнхий цэргийн 5 дугаар Армийн Артиллерийн командлагч бөгөөд хэлтсийн даргаар тус тус ажиллаж байлаа. 1987 онд энэ ажлаа өгөхтэй зэрэгцээд Батлан хамгаалах яамны сайд, дэслэгч генерал Ш.Жадамбаагийн хүсэлтээр оперативийн ерөнхий тасагт хоёр жил ажиллаад цэргийн албаны хугацаагаа дуусгасан. Одоо ах нь XX зууны хүүхэд, XXI зууны тэтгэврийн өвгөн болчихоод сууж байна даа.

(Үргэлжлэл нь VI нүүрт)

Бүх нийтээрээ гараа тогтмол угааж, амны хаалтаа зүүцгээе!

БОДЛОГО, ЗОРИЛТ

Б.Гантөмөр: АХЛАГЧ НАРЫН МАНЛАЙЛАЛ, ХАНДЛАГА, СЭТГЭЛГЭЭНЭЭС ЭЦСИЙН ҮР ДҮН ГАРАХ УЧИРТАЙ

ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Б.ГАНТӨМӨРӨӨС
Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүнд чиглэсэн энэ оны бодлого, чиглэлийн талаар тодрууллаа.

Эхлээд Зэвсэгт хүчний ахлагчийн албаны хөгжлийн талаар тодотгохгүй юу?

-Дэлхийн олон орон, бүс нутагт явагдаж байгаа дайн, зэвсэгт мөргөлдөөн, түүнд оролцогч талуудын хүн хүч, зэвсэг техникийн талаарх дүгнэлтүүдийг ажиглахад улс орнуудын Зэвсэгт хүчний хөгжлийн чиг хандлага нь орчин үеийн шилдэг технологид суурилсан зэвсэглэл, техникийн хөгжил түүнийг эзэмшигч мэргэжлийн өндөр ур чадвартай ахлагч, цэргийн гэрээт алба хаагчидтай байх нийтлэг шинжтэй өрсөлдөөн явж байгааг харж болохоор байна. Монгол Улсын Зэвсэгт хүчний сүүлийн 30 жилийн хөгжил, шинэчлэлийн нэг хэсэг нь ахлагчийн албыг шинэчлэх, хөгжүүлэх асуудал байсан. Ахлагчийн албаны хөгжлийг тоймлон авч үзвэл 1991 онд тухайн үеийн ЦИС-ийн бүтэцэд Цэргийн хөгжмийн сургууль, 1993 онд Ахлагчийн сургуулийг байгуулж мэргэжлийн ахлагч нарыг бэлтгэж эхэлсэн.

(Үргэлжлэл нь II нүүрт)

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ТУСГАЙ ХҮЧНҮҮД СУРГАЛТ БЭЛТГЭЛЭЭ ХЭРХЭН ЯВУУЛДАГ ВЭ

Өнгөрсөн жил Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор хөгжлийнхөө явцад өмнө нь байгаагүйгээр өргөжин хөгжих боломж нээгдэж, төрлийн цэрэгт Тусгай хүчний, Кибер аюулгүй байдлын, Барилга-инженерийн цэрэг нэмэгдсэн юм. Өөрөөр хэлбэл, ихэнх улс орнууд Зэвсэгт хүчиндээ тусгай хүчний бүлэг, салбар, нэгж, төрлийн цэрэгтэй байдгийн адилаар манай улс дээрх гурван командлалыг шинээр байгуулаад байна.

Орчин үеийн дайн, байлдаан, зэвсэгт мөргөлдөөн нь хосолмол дайны шинж чанарыг агуулах болсон гэж олон улсын цэргийн шинжээчид үзэж буй. Энэ нь уламжлалт дайны арга, тактикаас эрс ялгаатай гэсэн үг. Хил хязгааргүй, тогтсон стандартгүй, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт нь ойлгомжгүй, хамгийн орчин үеийн зэвсэглэл,

техникийг ашигладаг, зохион байгуулалттай гэмт хэргийн, шашны бүлэглэл, тусгайлан бэлдсэн цэргийн хүчнийг ашиглаж хүссэн үр дүндээ хүрдэг зэрэг олон чанарыг агуулах болжээ. Иймд дэлхийн олон улс орчин үеийн дайны шинж чанарын өөрчлөлттэй уялдуулан тусгай хүчний цэргийг хөгжүүлж байна. Www.special-ops.com цахим хуудсанд бичсэнээр дэлхийн хамгийн шилдэг тусгай хүчний цэрэгтэй таван улсаар АНУ-ын Тэнгисийн цэргийн "NAVY SEALs", Их Британийн Эзэн хааны Тэнгисийн цэргийн "NAVY SEALs", Израилийн Тусгай хүчний Саярат Маткал "Sayeret Matkal", Францын Тусгай хүчний "GIGN", ОХУ-ын Альфа бүлэг "Alpha group" тус тус багтсан байна. Иймд уншигчдадаа эдгээр шилдэг тусгай хүчний сургалт бэлтгэл, элсэлтийн талаарх мэдээллүүдээс хүргэе.

(Үргэлжлэл нь VII нүүрт)

Х.Баттулга: УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГҮҮДИЙГ ШИНЭЧЛЭН МӨРДӨХ НЬ ТА БҮХНИЙ ҮҮРЭГ

(Түрүүч нь I нүүрт)

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга хэлсэн үгэндээ: “Эрхэм генерал, офицерууд Та бүхний амрыг эрье.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдал, нутаг дэвсгэрийн

чадавх, бодит боломжид нийцсэн “мэргэжлийн чиг баримжаатай цомхон, чадварлаг Зэвсэгт хүчинтэй байх”, “мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бүрдүүлж хөгжүүлэх” бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн бүрэн эрхийн хүрээнд 2020 оны 6

Та бүхний үүрэг юм.

Ингэхдээ “Зэвсэгт хүчин нэгдмэл байх” зарчимд нийцүүлэн Төрийн цэргийн байгууллага, төрлийн цэргийн командлалын үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангах, улс орныхоо хүн ам, эдийн засгийн чадавхыг бодитоор тооцох, зэвсэгт тэмцлийн үеийн цэргийн ажиллагааны оршин тогтнохуйн аюулгүй байдалд нөлөөлөх

хамтран гүйцэтгэж байна. Төсөлд оролцсоноор барилга-инженерийн ангиудын чадавх, бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар нэмэгдэж, цаашид улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд бие даан үүрэг гүйцэтгэх боломжтой болсон гэж үзэж байна. Зэвсэгт хүчин цаашид Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан төмөр замын болон бусад стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтад үүрэг гүйцэтгэнэ.

Төмөр замыг өөрсдийн хүчээр буюу Зэвсэгт хүчин хариуцан, үндэсний аж ахуйн нэгжүүдийн оролцоотой бүтээн байгуулсан нь бид өөрсдөө чадна гэсэн итгэл үнэмшил, үндэсний ухамсрыг бий болгосон. Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын ажлыг монголчууд бид өөрсдөө хийх нь улс, үндэстнийхээ ирээдүйн сайн сайхныг бие даан цогцлоох, үндэсний аюулгүй байдлаа хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс нь болох болно.

Энэ дашрамд Монгол Улс энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, нээлттэй гадаад бодлогыг баримтлан, үндэсний аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ зорилтыг хангахад энхийг сахиулагчдын маань үүрэг, үйл хэрэг үнэтэй хувь нэмэр оруулж байгаа төдийгүй улс орныхоо аюулгүй байдал, оршин тогтнохын баталгааг бэхжүүлэхэд онцгой чухал ач холбогдолтойг мөн цохон тэмдэглэе.

Зэвсэгт хүчний байгуулалтын зорилго нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах улс төр, дипломатын үйл ажиллагаа, улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх чадавхтай цэргийн мэргэжлийн

өндөр түвшинд бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан орчин үеийн зэвсэглэл, цэргийн техник бүхий мэргэжлийн Зэвсэгт хүчнийг байгуулах алсын хараатай байх, цэргийн удирдлагын байгууллага, нэгтгэл, ангийн бэлэн байдал, бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийг аюулгүй байдлын орчинд нийцүүлэн дээшлүүлэхэд чиглэгдэнэ. Үүнд удирдах албан тушаалтнууд Та бүхэн онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

Та бүхний энэ удаагийн цугларалт нь улс орныхоо аюулгүй байдлыг бие даан хангахад чиглэсэн операцын төлөвлөлтийн баримт бичгүүдийг шинээр боловсруулах талаар нэгдсэн ойлголтод хүрэх, хүч хэрэгслийг оновчтойгоор хэрэглэх арга замыг эрэлхийлж байгаа гэж ойлгож байна.

Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний 2021 оны стратегийн цугларалтын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг Бүх цэргийн Их хар сүлд ивээж, Мөнх тэнгэрийн хүчин дор монгол цэргийн сур хүч, хийморь золбоо үеийн үед мандан бадрах болтугай” гэлээ.

Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд 1997 оноос хойш жил бүр зохион байгуулж буй Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтаар улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин, цэргийн байгууллагын өмнө тулгамдсан асуудлуудыг хэлэлцдэг юм.

Энэ үеэр улс орны стратегийн томоохон бүтээн байгуулалт болох Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын бүтээн байгуулалтын загварыг Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцууллаа.



бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалах хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй үйлсэд мөр зэрэгцэн, өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж буй төрийн цэргийн байгууллагын удирдах бүрэлдэхүүн, генерал, офицерууд Та бүхэнтэй энэ өдөр дахин уулзаж байгаадаа баяртай байна.

Шинэ үеийн түүхийн хугацаанд бид Үндсэн хуульдаа “Монгол Улсөөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчинтэй байх”-ыг хуульчлан баталгаажуулж, Зэвсэгт хүчин иргэний хяналтад байх ардчилсан нийгмийн үнэт зарчим, улс орны эдийн засгийн

дугаар сард хэд хэдэн баримт бичгийг баталгаажуулсан. Тэдгээрийн үзэл санаа Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалтай нийцэж, Зэвсэгт хүчний бүтцэд Тусгай хүчний цэрэг, Барилга-инженерийн цэрэг болон Кибер аюулгүй байдлын цэргийг бас байгуулсан. Цаашид шинээр байгуулагдсан төрлийн цэргийг тайван цагт болон дайны үед хэрэглэх, тайван цагт бэлэн байдал, бэлтгэлжилтийг нь хөргөн хангах удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг шинэчлэн мөрдөх нь

цэрэг-улс төр, цэрэг-стратегийн нөлөөллийг урьдчилан тооцох, даргалах албан тушаалын ахлагчаас генерал хүртэлх албан тушаалтнуудын санаа бодлыг тусгах шаардлагатай юм.

Зэвсэгт хүчний Барилга-инженерийн анги, салбарууд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн “Шинэ төмөр зам” төслийн бүтээн байгуулалтад үүрэг гүйцэтгэж, төмөр замын доод бүтцийг барих ажлыг хугацаанд нь дуусгаж, дээд бүтэц угсрах ажлыг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компани

БОДЛОГО, ЗОРИЛТ

Б.Гантөмөр: АХЛАГЧ НАРЫН МАНЛАЙЛАЛ, ХАНДЛАГА, СЭТГЭЛГЭЭНЭЭС ЭЦСИЙН ҮР ДҮН ГАРАХ УЧИРТАЙ

(Түрүүч нь I нүүрт)

Түүнчлэн 1996 оноос байнгын бүрэлдэхүүнтэй мэргэжлийн ангиуд бий болсон, 2003 онд ахлагчийн цолны зэрэглэлд, 2006 онд албан тушаалын ангилалд өөрчлөлт орсон, 2007 оноос “Ахлагчийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн, 2008 онд “Ахлагчийн алба хаах журам”, 2010 оноос даргалах албан тушаалын ахлагч нарын шаталсан сургалт, 2012 онд ахлагчийн цалингийн шатлалыг нэмэгдүүлсэн, 2014 онд ахлагчийн түвшин тогтоох шалгалтыг зохион байгуулсан гэх зэргээр ахлагчийн бүрэлдэхүүн рүү чиглэсэн шат дараатай олон ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн.

Мөн Косова, Ирак, Афганистаны Олон улсын цэргийн ажиллагаа болон Сьерра-Леон, Чад, БНСУ дахь энхийг дэмжих ажиллагаанууд, гадаад орнуудтай хамтарсан сургалт, дадлагуудад ахлагч нар олноор оролцож байлдааны үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийн түвшнийг тасралтгүй нэмэгдүүлж ирсэн. Үүнээс гадна гадаад орнуудын Зэвсэгт хүчний ахлагчийн албаны хөгжлийн чиг хандлагыг судлан АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан сургалт, дадлагуудыг олон чиглэлээр зохион байгуулж, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад ахлагч нарыг сурган мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлж байна.

Ахлагчийн албыг хөгжүүлэх, шинэчлэх үйл ажиллагаа одоо ч үргэлжлэн явагдсаар байна. Тухайлбал Зэвсэгт хүчний “Ахлагчийн албаны үнэт зүйл, алсын хараа, эрхэм зорилго”-ыг тодорхойлж, ЗХЖШ-ын даргын тушаалаар батлуулж мөрдлөг болгон ажиллаж байна.

“Ахлагчийн албыг хөгжүүлэх хөтөлбөр-2021” хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнийн талаар мэдээлэл өгнө үү. Таван жилийн өмнө Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлагдсан тус хөтөлбөрийн хугацаа энэ жил дуусгавар болно шүү дээ?

-Батлан хамгаалахын сайдын 2015 оны 12 дугаар сарын 31-нд баталсан “Ахлагчийн албыг хөгжүүлэх хөтөлбөр-2021” хөгжлийн хөтөлбөрийг үндсэн гурван зорилт, 12 чиглэлийн хүрээнд нийт 65 ажил,

арга хэмжээг хоёр үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Өнгөрсөн онд ЗХЖШ-ын Хяналт, шалгалт үнэлгээний газраас хийгдсэн үнэлгээгээр хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн. Хөтөлбөрийн хувьд ахлагчийн албаны эрх зүйн орчныг сайжруулах, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэжлийн ур чадварыг сайжруулах зэрэг зорилтот арга хэмжээнүүд амжилттай явагдаж байна. Гэсэн хэдий ч нийгмийн хамгаалалтай холбоотой зарим зорилтот ажлууд төвсвийн хязгаарлагдмал байдалтай холбоотойгоор хэрэгжих боломжгүйд хүрсэн. Тиймээс хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч, хөтөлбөрт тодотгол хийж төрлийн цэргийн командлал, нэгтгэл, ангиудад хийх үйл ажиллагааны чиглэлүүдийг хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Улс орны хэмжээний томоохон бүтээн байгуулалтын ажилд ахлагчийн бүрэлдэхүүн идэвхтэй оролцохоос гадна мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтын асуудалд онцгой анхаарч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсролын газартай хамтран Политехникийн коллеж, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг түшиглэсэн сургалтаар ҮБХИС-ийн Ахлагчийн сургуульд бэлтгэгддэггүй мэргэжлээр цэргийн алба хаагчдыг бэлтгээд байна. Одоогийн байдлаар Зэвсэгт хүчний 017 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж буй дайчдад барилгын өргөн мэргэжлээр мэргэжил олгох сургалтыг зохион байгуулж байна.

Энэ жилийг “Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний бие бялдрын бэлтгэлжилт, эрүүл мэндийг дээшлүүлэх жил” болгон зарласан. Энэ хүрээнд ямар ажлууд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бэ?

-Энэ онд хэрэгжүүлэх нэг томоохон ажил бол Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх хүрээнд “Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний бие бялдрын бэлтгэлжилт, эрүүл мэндийг дээшлүүлэх жил” болгон зарласан юм. Үүнтэй холбоотой тушаал шийдвэр, зөвлөмж, чиглэлүүд гарч ЗХЖШ, төрлийн цэргийн командлалууд, нэгтгэл, анги бүрт ажлын хэсэг байгуулагдан цар тахлаас урьдчилан сэргийлэх онцгой нөхцөл байдалтай уялдуулан үйл



ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Шат дараалсан удирдлагын дэмжлэг, ажлын хэсгүүдийн идэвх, зөв төлөвлөлт, нийт ахлагч нарын манлайлал, хандлага, сэтгэлгээнээс энэ ажлын эцсийн үр дүн гарна. Тийм учраас Зэвсэгт хүчний ахлагчийнхаа бүрэлдэхүүнийг хичээл зүтгэл гарган ажиллахыг уриалъя.

Ахлагчийн бүрэлдэхүүний цаашдын хөгжил, түүнд чиглэсэн зорилго, төлөвлөлтийн тухайд та юу хэлэх вэ?

-Дээр дурдсан томоохон ажил, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээс гадна ахлагчийн албаны ёс зүй, сахилга хариуцлага, сургалт бэлтгэл, нийгмийн хамгаалалд чиглэсэн олон ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Удахгүй ахлагчийн шаталсан сургалтын стандартыг шинэчлэн батлуулна. Мөн Зэвсэгт хүчний ахлагчийн албыг хөгжүүлэх дараагийн хөтөлбөрийг боловсруулах, ахлагчийн албаны түүхэн эх сурвалжуудыг судалж эмхэтгэх, “Ахлагч хотхон” хорооллын орон сууцны барилгыг

эхлүүлэх зэрэг олон ажлыг хэрэгжүүлнэ.

Энэ жил БХЯ-ны 110 жил, Зэвсэгт хүчний 100 жилийн түүхэн ой тохиож буй. Энэ хүрээнд ахлагчийн бүрэлдэхүүнтэй уялдаатай ямар ажлууд хийгдэх вэ?

-Дээрх ойнуудыг угтан Зэвсэгт хүчний нийт офицер, ахлагчийн бүрэлдэхүүн өөрсдийн санаачилга, хандиваар Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх “Монгол цэрэг-Энхийн төлөө цогцолбор”-т энхийг сахиулагчдын хөшөө, жагсаалын талбай, зам, ногоон байгууламж зэрэг ажлыг хийлээ. Цаашид батлагдсан зураг төслийн дагуу тус цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Дашрамд хэлэхэд уг ажлыг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцсон Зэвсэгт хүчний нийт офицер, ахлагч нартаа “Соёмбо” сониноор дамжуулан талархалаа илэрхийлжээ.

Ахмад Д.МЭНДБАЯР

АГААРЫН ЦЭРГИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛНЭ

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Ганхуяг нар Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын үйл ажиллагаатай танилцуулав. Энэ үеэр Агаарын цэргийн командлагч, бригадын генерал О.Энхбаяр командлалынхаа үйл ажиллагааг танилцуулж, Агаарын цэргийн үндсэн болон тайван цагт хуулиар хүлээсэн үүргүүдийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх гарц шийдлийн талаар мэдээлэл өгөв.

Дэд сайд болон Төрийн нарийн бичгийн дарга танилцуулгатай уялдуулж зарим асуудлын талаар тодруулсан бөгөөд Агаарын цэргийн командлагчийн зөвлөлийн

гишүүд холбогдох чиглэлээр хариулт өгсөн юм.

Дэд сайд Б.Баярмагнай хэлсэн үгэндээ, "Ажлаа хүлээж аваад Батлан хамгаалахын сайдын өгсөн үүргийн дагуу баруун бүс дэх анги, салбаруудад ажилласан. Ингэхдээ Агаарын цэргийн зарим анги, салбарын үйл ажиллагаатай танилцаж, тулгамдаад буй хүндрэл бэрхшээлүүдийг ойлгож мэдэрсэн. Ялангуяа, бие бүрэлдэхүүний ажиллаж, амьдрах ая тухтай орчин нөхцөлийг сайжруулах, зэвсэглэл, техникийн үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэхэд анхаарах ёстойг анзаарсан" хэмээн онцолсон. Мөн тэр бээр тулгамдаж буй асуудлуудаа цаг хугацааны хувьд эрэмбэлээд, тухайн асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага, түүний үр дүнг бодитоор тооцоолон танилцуулга бэлтгэж яамны



удирдлагуудад хүргүүлэхийг үүрэг болголоо.

Түүнчлэн Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Ганхуяг "Өнгөрсөн жилүүдэд Агаарын цэргийн зэвсэглэл, техникийг сайжруулахад чиглэсэн зарим

төлөвлөгөөт ажил тодорхой шалтгааны улмаас хэрэгжээгүй. Агаарын цэргийн зэвсэглэл, техникийн чанар муудсан, хоцрогдсон гэдгийг БХЯ, ЗХЖШ-ын удирдлага бүрэн ойлгож, мэдэрч байгаа. Тиймээс дээрх асуудлыг

зохиж хэмжээгээр шийдвэрлэх, шинэ бүтээлч санаачилгыг дэмжих чиглэлээр Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас энэ онд тодорхой хөрөнгө зарцуулахаар шийдвэрлэсэн" гэж онцолсон юм.

Дашрамд дурдахад, "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-нд БХЯ нь "Монгол Улсын Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ" гэсэн тэргүүлэх зорилтын хүрээнд есөн дэд зорилт, 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасны гурван томоохон ажил нь Агаарын цэргийн чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэгджээ.

Ж.Болдбаатар: ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛДЭГ БАЙХ НЬ НЭН ТЭРГҮҮНИЙ АСУУДАЛ

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.БОЛДБААТАРТАЙ ярилцлаа.

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч болон түүний харьяа ажлын алба бий болсон зорилго, хэрэгцээ шаардлагын талаар тодруулахгүй юу?

-Батлан хамгаалах тухай хуульд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд ямар үүрэгтэйг тодорхой заасан байдаг. Тухайлбал, Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийг томилж, чөлөөлнө гэж заасан. Уг хуулийн заалтын дагуу Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч томилогдож, үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн Засгийн газрын 2020 оны 58 дугаар тогтоолоор Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын нэгж, түүний үндсэн чиг үүргийг тогтоож өгснөөр ажлын алба бий болсон. Батлан хамгаалахын сайд нь Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд иргэний хяналт тавих үүрэгтэй. Энэ үүргийг Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч нь Батлан хамгаалахын сайдын өмнөөс төрийн цэргийн байгууллагад иргэний хяналт тавьж, уялдаа холбоотой ажиллах учиртай юм. Үндсэндээ Батлан хамгаалахын сайдаас Батлан хамгаалах хяналт, шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албыг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. Мөн Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/310 дугаар тушаалаар Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн дүрмийг баталсан.

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн үндсэн үүрэг юу вэ?

-Батлан хамгаалахын хяналт шалгалт, үнэлгээний бодлого, чиглэлийг тус салбарт тодорхойлж, Батлан хамгаалахын болон Зэвсэгт хүчний хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын уялдаа холбоог зохицуулах, зөвлөмж гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах үндсэн үүрэг хүлээнэ.

Өөрөөр хэлбэл БХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрыг нэгдмэл бодлогоор хангана гэсэн үг. Үндсэн үүрэг чиглэлийн хүрээнд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм журам, норм стандарт, эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах санал, зөвлөмжийг гаргана.

Мөн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, гарсан зөрчлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх арга хэмжээ, сургалт зэргийг зохион байгуулах юм.

Хяналт шалгалтын байгууллага гэхээр шалгадаг, нөгөө талаас торгож шийтгэдэг гэсэн ойлголттой байж болохгүй. Харин эрсдэлээс урьдчилан сэргийлдэг байх нь нэн тэргүүний асуудал. Бидний хувьд нэгдмэл

хяналт шалгалтын бодлогыг явуулах ёстой болсон. Энэхүү нэгдмэл бодлого, үйл ажиллагаа нь нэг нь нэгнийгээ ойлгох, хамтран ажиллахаас эхэлнэ. Нэгдмэл бодлогын хүрээнд хууль эрх зүйн гарын авлага, эмхэтгэл гаргаж, сургалтуудыг зохион байгуулна. Дараа нь сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил бий. Дээр дурдсан гурав нь Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн ажлын албаны гол ажил нь байх ёстой гэж харж байна. Мэдээж байгууллагад хийгдэх үзлэг, хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх нь бүтцийн нэгжийн хариуцах асуудлуудын нэг. Дараагийн дугаарт төрийн албан хаагч, тэр дундаа удирдах тушаалын албан хаагчийн төрийн албаны ёс зүйн асуудал орж ирнэ. Бид ёс зүйтэй төрийн алба, ёс зүйтэй төрийн албан хаагч гэсэн том ойлголтыг гаргаж тавих хэрэгтэй. Зөрчил дутагдал илрэхээс өмнө төрлийн цэргийн командлал, анги, байгууллагын алба хаагчдад урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн зохион байгуулах вэ гэдэг нь чухал.

Батлан хамгаалах салбарын төсвийн ерөнхийлөн захиралын удирдлагад БХЯ-ны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, анги, байгууллагуудын 80 гаруй төсвийн захирагч нар байна. Эдгээр албан тушаалтантай гурван өдрийн сургалтыг гурван төрлийн агуулгатайгаар зохион байгуулсан. Нэгдүгээрт, байгууллагын дотоод хяналт шалгалтыг хэрхэн явуулах тухайд юм. Дотоод хяналт гэдэг нь ганц санхүүгийн асуудал биш. Сахилга, зохион байгуулалт, дэг журам, ашиг сонирхлоос ангид байх, ажилтан, албан хаагчийн ёс суртахуун, зан харилцаа зэргийг хөндсөн. Хүн хоорондын харилцаа нь том соёл байх ёстой. Төрийн ажил харилцаанд суурилсан байдаг. Тиймээс хүн хоорондын харилцааны соёлыг үнэлгээ, дүгнэлт аудит хийдэг үйл ажиллагаатай хэрхэн зохицолдуулах вэ гэдгийг тодорхойлж өгөх нь чухал.

Дараагийн дугаарт, төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хөндөх нь зүйтэй. Салбарын алба хаагчидтай холбоотой зөрчил, дутагдал таслан зогсоогдохгүй байна. Үүнийг бууруулж, арилгахад сургалтын зорилго, агуулга чиглэгдсэн. Гуравдугаарт, санхүүгийн сахилга батын асуудал. Бид санхүүгийн мэдлэг, боловсрол нимгэнээс асуудал үүсдэг гэж харж байна. Хүний ноцтой хариуцлагагүй үйлдэл, хандлага гэж бодохгүй байна. Санхүүгийн бодлого дутмаг байгаагийн илрэл байх. Энэ чиглэлээр дэмжих хэрэгтэй. Дээр дурдсан бидний үндсэн сургалт маань байгууллагын дотоод хяналт, шалгалтыг хэрхэн явуулах, авилга ашиг сонирхлын зөрчлөөс хэрхэн ангид байж, түүнээс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүйг яаж өндөр түвшинд сахиж зэрэг асуудлыг хөндсөн. Санхүүгийн

сахилга баттай холбож ярихад татвар төлөгч нарын мөнгийг бид хэрхэн зөв зохистой зарцуулж, нээлттэй байлгах вэ. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангах вэ гэх зэрэг чиглэл бүрээр нь авч үзэх асуудлууд бий.

Бид хяналт шалгалтын байгууллагыг эрх зүй талаас нь хэрхэн, яаж гаргаж ирэх ёстой вэ гэдгийг харсан. Хууль, эрх зүйн хувьд ажиллах нөхцөл боломжоор нь бүрэн хангах ёстой. Бид Батлан хамгаалахын сайдын тушаалаар байгууллагын дотоод хяналт шалгалт, санхүүгийн хяналт шалгалтыг зохион байгуулах журмуудыг батлуулсан. Дараа нь үүнтэй холбогдуулан гарын авлага гаргаж бүх байгууллагуудад тарааж, сургалт зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээний хүрээнд Батлан хамгаалахын сайд "Батлан хамгаалахын нэгдмэл хяналт" сэдвээр батлан хамгаалахын хяналт шалгалтын нэгжүүдийн алба хаагчдад тодорхой үүрэг чиглэл өгсөн.

Таны хувьд ямар бодлого барьж ажиллах вэ?

-Ер нь Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн гэхээсээ илүү Батлан хамгаалахын сайдын барьж буй бодлого гэж харах нь зөв болов уу. Батлан хамгаалахын салбарт хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн бодлогыг барьж ажиллана. Харин үүнийг Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч ба түүний ажлын алба зангидаж ажиллах ёстой. Нэг ёсны БХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, харьяа аж ахуйн нэгж, байгууллагууд, Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар, командлал, нэгтгэл, ангиудын хяналт шалгалтын бодлогыг нэгдмэл байлгаж, зангидагна гэсэн үг. Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд бол Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө энэ салбарыг төлөөлж хариуцлага хүлээдэг. Тиймээс Батлан хамгаалахын сайдын хувьд нэгдмэл бодлого барьж ажиллаж байна. Харин бодлогын доторх агуулга нь урьдчилан сэргийлэх, сургалт, соён гэгээрүүлэх ажлыг түлхүү явуулах гэсэн зорилготой.

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч мөрдлөг болгож ажиллах дүрмийн талаар танилцуулахгүй юу?

-Дүрмийн зорилго нь Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн эрх зүйн байдал, чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлж, түүний үйл ажиллагаатай холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино. Мөн үйл ажиллагаандаа Үндсэн хууль, аюулгүй байдал, батлан хамгаалахын багц хуулиуд, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Аудитын тухай хууль, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдлөг болгоно. Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн дүрмээр хүлээсэн нийтлэг үндэслэл нь ийм.

Цаашилбал, үйл



ажиллагааны зарчим, үндсэн чиглэл, эрх үүрэг, ажлын албаны үүрэг, тавигдах шаардлага гээд үйл ажиллагааг нь тодорхой нарийвчлалтайгаар тайлбарласан зүйлс бий.

Хяналт шалгалтаар хэн нэгнийг хянаж шалгана гэж айлгахаасаа илүү урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхэд анхаардаг байх учиртай гэж хэлсэн. Ер нь дотоод хяналт шалгалтыг өндөр түвшинд зохион байгуулахдаа юуг гол болгож ажиллах вэ?

-"Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг оны өмнө Батлан хамгаалахын сайдын А/294 дүгээр тушаалаар баталж, хэрэгжилтийг зохион байгуулахыг Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчид үүрэг болгосон. Энэхүү журмын зорилго нь БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, харьяа аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт шалгалттай холбогдсон харилцааг зохицуулсан.

Үндсэндээ Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, хуулиар олгогдсон эрх бүхий албан тушаалтны гаргасан эрх зүйн баримт бичиг болон энэхүү журмыг удирдлага болгож Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах юм.

Ингэснээр хяналт шалгалт хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга бодитой, нэгдмэл төлөвлөлт, зохион байгуулалттай, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана гэсэн үг.

Танай ажлын албаны үйл ажиллагаа, үндсэн үүргийн талаар ...

-Ажлын албаны хувьд хамгийн чухал нь Батлан хамгаалах салбарт Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, тэдгээрт нийцүүлэн хуулиар олгогдсон бүхий л эрх бүхий албан тушаалтан, Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын баталсан эрх зүйн баримт бичиг, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ёстой. Мөн Батлан хамгаалахын сайдыг бодит мэдээллээр хангах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллана. Түүнчлэн Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд мөрдөгдөж буй хууль, дүрэм

журам, норм стандарт, эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох талаар судалгаа шинжилгээ хийх, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах санал зөвлөмж гаргах, хяналт шалгалтын нэгдсэн санг бүрдүүлэх гэх мэтээр зохион байгуулалт, төлөвлөлтийн өндөр түвшинд, аливаад шинжлэх ухаанч байдлаар хандаж ажиллана гэж ойлгож болно.

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн дүрэмд ажлын албатай байна гэж заасан. Энэхүү ажлын албаны хувьд тодорхой үүрэгтэй. Тухайлбал, Батлан хамгаалах хууль тогтоомж, төрийн батлан хамгаалах бодлого, хөгжлийн стратеги, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хянах төрийн болон нутгийн захиргааны байгууллагад хяналт-шинжилгээ хийж дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Батлан хамгаалахын хяналт, шалгалтын ажлын нэгдсэн төлөвлөлтийг БХЯ, Зэвсэгт хүчний хяналт, шалгалтын нэгжүүдтэй хамтран боловсруулах, тайлан, дүн мэдээг нэгтгэж дүгнэх, гэмт хэрэг, алдаа дутагдлын шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, арилгуулах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ, сургалт зохион байгуулах гэх мэт үйл ажиллагаатай нягт уялдсан үүрэгтэйгээр ажиллана.

Он гараад Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Батлан хамгаалахын хяналт шалгалтын 2021 оны нэгдсэн төлөвлөгөө, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг Засгийн газрын 2020 оны 238 дугаар тогтоолоор 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасантай холбогдуулан "Батлан хамгаалах салбарын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн үед ажиллах төлөвлөгөө"-г тус тус боловсруулан холбогдох албан тушаалтнуудад танилцуулан батлуулаад байна.

Дээр дурдсан үүргүүдээс таны хэлсэн нэгдмэл бодлого, зохион байгуулалт түлхүү харагдаж байх шиг ...

-Төрийн захиргааны удирдлагын тогтолцооны хувьд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын алба, БХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар гэсэн бүтцийн хяналт, шалгалтын үйл ажиллагааг нэгдмэл төлөвлөлт, зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх боломжтой болсон гэдгийг Батлан хамгаалахын сайд илэрхийлсэн. Мөн Ерөнхий хянан шалгагчийн үйл ажиллагааны бодлогод туссан үндсэн үүрэгт Батлан хамгаалахын болон Зэвсэгт хүчний хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын нэгжийг нэгдсэн удирдамжаар хангах, ажлын уялдаа холбоог зохицуулах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах тухай тодорхой заасан талаар хэлсэн. Тиймээс ажлын албаны үүрэг ч үүнтэй нягт уялдсан байх нь зүйн хэрэг юм.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ



АЛДАР 75 ЖИЛ

ТҮҮХЭН ЗАМНАЛ

МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсын биеийн тамир спортын анхдагч байгууллага, Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны

**АМЖИЛТЫН ТӨЛӨӨ-АЛДАРЫНХАН ХАМТДАА
ДАРГА, ХУРАНДАА Г.ӨСӨХБАЯР**

түүхт 75 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын тусгаар тогтнол, Батлан хамгаалах үйлсэд хүчин зүтгэж буй Зэвсэгт хүчний нийт алба хаагч, үе үеийн удирдлага, багш дасгалжуулагч, тамирчид, спорт хорооны нийт бүрэлдэхүүнд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж, түүхт ойн баярын мэнд хүргэе.

Тэртээх 1946 оны 2 дугаар сарын 2-ны өдөр БНМАУ-ын МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 6 дугаар тогтоолоор Цэргийн явдлын яамыг түшиглэн Цэргийн газар, хотын залуучуудыг хамруулан "Цэрэг" нэртэй спортын байгууллагыг анхлан байгуулснаас хойш Монгол Улс, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нэрийг тив дэлхий, олимпын тавцанд өндөрт өргөсөн

тамирчдыг бэлтгэн гаргасаар байна.

"Алдар" спорт хороо үүсэн байгуулагдсан цагаасаа улс орны нийгэм, төрийн байгууллагын хөгжлийн бүхий л үе шатуудад бэхжин хөгжиж, спортын алдар гавьяатан олноор төрөн гарч, хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж ирснийг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Спорт хорооны түүхэн замналыг бичилцэж буй манай үеийнхэн уламжлалаа хүндэтгэн, спортын амжилтаа бататгаж, хуулиар хүлээсэн үүргээ үнэнчээр биелүүлнэ гэдгээ илэрхийлж, ойн баярын мэндийг дахин дэвшүүлж, спортын өндөр амжилт, амьдралд тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ДЭЛХИЙН ЦЭРГИЙН СПОРТЫН ХОЛБОО /CISM/

Дэлхийн II дайны дараа энх тайвныг тогтоох, түүгээр дэлгэрүүлэх зорилгоор 1948 онд Дэлхийн цэргийн спортын байгууллага (CISM) байгуулагдаж, улс орнуудын цэргийн алба хаагчдын дунд спортын уралдаан, тэмцээнүүдийг явуулж эхэлсэн юм. Франц, Дани, Бельги, Люксембург, Голланд нь CISM-ийг үүсгэн байгуулагч анхны таван оронд тооцогддог.

Дэлхийн цэргийн спортын байгууллагын үндсэн зорилго нь улс орнуудын цэргийн алба хаагчид дайн тулааны талбарт бус спортын тавцанд өрсөлдөгч, найз нөхөд байхыг чухалчилдаг энхтайван, эв нэгдлийн гүүр болох сайн санааны байгууллага юм. Өдгөө CISM-д дэлхийн 133 орон гишүүнээр элссэн бөгөөд дээд удирдлага нь Бельгийн

спортын байгууллагуудын аварга шалгаруулах тэмцээнийг "Бага дэлхийн аварга" гэж нэрлэдэг. Учир нь аль ч орны шилдэг тамирчид тухайн орныхоо Зэвсэгт хүчний спортын байгууллагад харьяалагддаг. Тэр утгаараа тэдгээр тамирчид олимп, тив, ДАШТ-д өндөр амжилт үзүүлдэг.

Монгол Улсын Зэвсэгт хүчин 1992 онд Дэлхийн цэргийн спортын байгууллагад элсэн орох анхны албан бичгийг CISM-ийн Ерөнхий нарийн бичгийн даргад гардуулж, тус ондоо Бээжин хотноо зохиогдсон CISM-ийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнд баг тамирчдаа бэлтгэн оролцуулж жинхэнэ гишүүнээр элссэн юм. Үүнээс хойш жүдо, чөлөөт бөхийн төрлүүдээр манай баг тамирчид оролцож, медальт байрт тогтмол шалгарах болсон.

дэлхийн 117 орны баг тамирчдаас 16 дугаар байрт шалгарсан амжилт үзүүлсэн.

ДЭЛХИЙН ЦЭРГИЙН СПОРТЫН ХОЛБООНЫ ЗҮҮН АЗИЙН ЖУДО БӨХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ АНХДУГААР ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Тэмцээнийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах тухай Батлан хамгаалахын сайдын тушаал 2017 онд гарч, тухайн үеийн Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдоржор ахлуулсан БХЯ, ЗХЖШ, "Алдар" спорт хороо, Монголын Жудо бөхийн холбооны хамтарсан ажлын хэсэг томилогдож, зохих бэлтгэлийг хангасан юм.

Ийнхүү тэмцээнийг Буянт-Ухаа спорт цогцолборт зохион байгуулж медалийн тоогоор ОХУ долоон алт, хоёр мөнгө, дөрвөн хүрэл медаль хүртсэн амжилтаар тэргүүлж, Монгол Улсын баг дөрвөн алт, таван мөнгө, 10 хүрэл медаль хүртсэн амжилтаар удаалсан бол БНАСАУ-ын баг хоёр алт, гурван мөнгө, 10 хүрэл медаль хүртсэн амжилтаар гурвдугаар байрыг тус тус эзэлсэн.

Дэлхийн цэргийн спортын холбооны 2017 оны календарчилсан төлөвлөгөөний дагуу Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан Зүүн Азийн Жудо бөхийн аварга шалгаруулах тэмцээнийг 2017 оны 9 дүгээр сарын 5-11-нд амжилттай зохион байгуулсан нь Монгол Улс оролцогч орноос зохион байгуулагч орны тоонд орсон томоохон үйл явдал болсон юм.

ДЭЛХИЙН ЦЭРГИЙН СПОРТЫН VII ИХ НААДАМ Дөрвөн жил тутамд зохиогддог



БНСУ-ын Мунгён хотноо 2015 онд зохион байгуулагдсан Дэлхийн спортын VI их наадамд "Алдар" спорт хорооны баг тамирчид нь буудлага, бокс, байт сур, чөлөөт бөх, жүдо, дугуй, хөнгөн атлетик, таеквондо гэсэн найман төрлөөр 86 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, зургаан алт, 12 мөнгө, зургаан хүрэл медаль хүртсэн амжилтаар

Дэлхийн цэргийн спортын VII их наадам БНХАУ-ын Ухань хотноо 2019 онд амжилттай болж өнгөрсөн. Дэлхийн 109 орны 9300 гаруй тамирчин өрсөлдсөн тус наадам нь олимпын өмнөх жил зохион байгуулагдсанаараа дэлхийн шилдгүүд хуран чуулсан өндөр зэрэглэлийн тэмцээн болж чадсан. Уг наадамд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан 108 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид спортын 10 төрлөөр оролцсон байна. Наадмын нээлтийн үйл ажиллагаанд тухайн үеийн Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Н.Энхболд зохион байгуулагч орны урилгаар хүрэлцэн очиж, үзэж сонирхсон юм.

Манай баг тус тэмцээнд тамирчид амжилттай оролцож, нэг алт, гурван мөнгө, таван хүрэл, нийт есөн медаль хүртэж, дэлхийн 109 орноос 17 дугаар байрт шалгарсан түүхэн амжилтыг үзүүлсэн билээ.

Ардын хувьсгалын 25 жилийн ойг угтаж 1945 онд Монгол Улсын биеийн тамир, спортын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар дорвитой арга хэмжээ авч, нийтийн биеийн тамир, спортын ажлыг орон даяар удирдан хөгжүүлэх зөв тогтолцоонд шилжсэн нь өнөөгийн "Алдар" спорт хороо үүсч хөгжих нөхцөлийг бүрдүүлжээ. МАХН-ын төв хороо Сайд нарын зөвлөлийн 1946 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 6 дугаар тогтоолоор Ард, Соёл, Хөдөлмөр, Цэрэг, Хилчин гэдэг сайн дурын биеийн тамир спортын нийгэмлэгтэй болж БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дэргэдэх Биеийн тамир, спортын хороог байгуулжээ.

Тус тогтоолд цэргийн газрын биеийн тамирчдыг нэгтгэсэн спорт байгууллага нь "Цэрэг" хэмээн нэрлэгдэнэ гэж заажээ. Байгуулагдсан анхны өдрөөсөө эхлэн Ардын хувьсгалын түүхт ялалтын 25 жилийн ойн Үндэсний Их баяр наадам, Цэргийн явдлын яам, хотын 2000 гаруй залуусыг түшиглэн зохион байгуулагдсан улсын анхдугаар спартакиад болон түүнээс хойшх бүх төрлийн тэмцээн уралдаанд амжилттай оролцож ирсэн буухиатай.

Цэрэг нийгэмлэг нь 1954 он хүртэл сонсогч, цэрэг дайчид, офицеруудын бүрэлдэхүүний бие бялдрыг чийрэгжүүлэх, уралдаан тэмцээнд оролцуулдаг байв. НАХЯ-ны Байлдааны хэлтсийн биеийн тамир эрхэлсэн туслах бөгөөд армийн ерөнхий дасгалжуулагч "Алдар" нийгэмлэгийн дүрэм заавар боловсруулах комиссын дарга, хошууч Л.Чимэддорж энэ үүргийг хариуцан гүйцэтгэжээ.

1954 онд МАХН-ын төв хороо, Сайд нарын зөвлөлийн шийдвэрээр биеийн тамир, спортыг хөгжлийн шинэ шатанд гаргах спортын сайн дурын нийгэмлэгүүдийг улсын чанартай байгууллага болгох зорилгоор "Хоршоолол", "Туяа" гэх залгамжлагч нийгэмлэгийг шинээр байгуулж Цэрэг, Хилчин нийгэмлэгийг "Алдар", "Хүч" хэмээн нэрлэх болов. МАХН-ын Төв хорооны 1955 оны тогтоолоор "Биеийн тамир, спортын хэргийг эрхлэх хорооны зохион байгуулалтад өөрчлөлт оруулжээ. Уг тогтоолоор "Алдар" нийгэмлэгийг БХЯ-ны мэдэлд шилжүүлж түүнд Дотоод явдлын яам ба Батлан хамгаалах яамны спортын баазуудыг харьяалуулж, "Хүч" нийгэмлэгийг "Алдар"

нийгэмлэгтэй нэгтгэсэнээр "Алдар" нийгэмлэг нь Дотоод явдлын яамны бие бүрэлдэхүүний "Хүч" биеийн тамирын тасагтайгаар 1972 он хүртэл ажилласан юм.

1955 оноос бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж, "Алдар" нийгэмлэг нь орон тооны 15 тамирчин, Дотоод явдлын яам харьяалсан "Хүч" тасагтай болов. Энэ үеэс спортын түүхэнд улс орон, тив дэлхийд нэрээ дурсгасан олон зуун багш дасгалжуулагч, тамирчдыг төрүүлсэн биеийн тамир, спортын байгууллага болох гараагаа тавьж, хүчний байгууллагуудын дайчдын бие бялдар, чийрэгжүүлэлтийг сайжруулах, цэргийн анги, салбарт явагдах хичээл сургалтын төлөвлөгөө боловсруулж, улс, олон улсын уралдаан тэмцээнд тамирчдыг бэлтгэж оролцуулахын тулд материаллаг баазаа өргөтгөх нөр их ажлыг өрнүүлж эхэлжээ.

1960 оноос Монголын тамирчдын анхдугаар их хурал хуралдаж биеийн тамир, спортын байгууллагын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэж орчин үеийн спортын олон төрөл хөгжих, тив, дэлхийн тавцанд гарах шинэ үе эхлэв.

Анхдугаар спартакиадад оролцсон биеийн тамир, спортын "Алдар" нийгэмлэг хөтөлбөрт заагдсан спортын бүх төрөлд оролцож 41 тамирчин аварга цол, алтан медаль хүртэж, анхны аварга байгууллагаар өргөмжлөгдсөн түүхэн гавьяатай билээ.

Орон тооны тамирчин, шилдэг дайчдаас бүрдсэн спортын тусгай роттой болж улам хүчирхэгжихэд зах зээлийн шинэ тогтолцооны /1991-2005/ "халуухан" үе мөн эхлэв. Орон тоог цомхотгож, нэр хаяг өөрчлөгдөн аль нэг анги, байгууллагын хавсарга болон жигдэрч ЦНДС-ийн биеийн тамирын тэнхим, Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төв /311-р анги/, Зэвсэгт хүчний Ар тал, материал хангалтын төв бааз /310 дугаар анги/-ын харьяанд орж байсан эдийн засгийн хүнд үед БХЯ, ЗХЖШ-аас боломжоороо анхаарч ирсэн нь сайшаалтай.

БТС-ын улсын хорооны тушаалыг үндэслэн БХЯ-ны сайдын 2005 оны тушаалаар Биеийн тамир, спортын "Алдар" хороо болж тамга, тэмдэгт гардан авснаар эрин үетэйгээ зэрэгцсэн амжилт бүтээлийн он жилүүд нь эхэлсэн юм.

АМЖИЛТЫН ЦУУРАЙ

Олон мянган тамирчин дасгалжуулагч, Зэвсэгт хүчний Биеийн тамир, спортын "Алдар" спорт хорооноос спорт, амьдралын гараагаа эхлүүлж, түүхэнд дуурсагдах алдартан, эх орныхоо нэрийг өндөрт өргөх шилдэг амжилтын эзэд болсон билээ. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын шигшээ багийн нийт бүрэлдэхүүний 80 гаруй хувийг "Алдар" спорт хорооны тамирчид бүрдүүлж байгаа нь бидний амжилт, ажлын үзүүлэлтийн нэг хэсэг билээ.

Бидний бахархал:

- Монгол Улсын Хөдөлмөрийн Баатар	-4
- Монгол Улсын Төрийн соёрхолт	-1
- Монгол Улсын Ардын эмч	-1
- Монгол Улсын Ардын багш	-4
- Монгол Улсын гавьяат багш	-7
- Монгол Улсын гавьяат дасгалжуулагч	-20
- Монгол Улсын гавьяат зүтгэлтэн	-1
- Монгол Улсын гавьяат тамирчин	-41
- Монгол Улсын гавьяат жүжигчин	-3
- Монгол Улсын гавьяат нисгэгч	-1
- Монгол Улсын гавьяат хуульч	-1
- Монгол Улсын гавьяат малчин, агрономч	-2
- Монгол Улсын ААҮ-ний Гавьяат ажилтан	-2
- Монгол Улсын гавьяат эмч	-3
- Монгол Улсын генерал	-2
- Үндэсний бөхийн аварга	-14
- Үндэсний бөхийн арслан	-15
- Үндэсний бөхийн гарьд	-3
- Үндэсний бөхийн заан цолтон	-12
- Үндэсний бөхийн харцага цолтон	-30
- Үндэсний бөхийн начин цолтон	-83
- Аймаг цэргийн цолтой бөх	-146
- Үндэсний сурын мэргэн	-12
- Алдарт уяач	-19
- Олон улсын их мастер /шатрын/	-3
- Олон улсын хэмжээний мастер	-460
- Спортын мастер	-1320
- Спортын дэд мастер – 2578 гаруй төрөн гарсан байна.	

Дөрвөн жил тутамд зохион байгуулагддаг Монголын Бүх Ард Түмний спортын их наадам 14 удаа зохиогдоход 12 удаа тэргүүн, хоёр удаа дэд байрт шалгарсан. Монгол Улсын дээд амжилтыг давхардсан тоогоор 520 гаруй удаа шинэчлэн тогтоосон.

- Олимпын наадмаас хоёр мөнгө, таван хүрэл медаль
- Дэлхийн аваргын тэмцээнээс 12 алт, 23 мөнгө, 42 хүрэл медаль,
- Дэлхийн мастеруудын тэмцээнээс 13 алт, 10 мөнгө, 12 хүрэл медаль,
- Ази тив болон Азийн тоглолтоос 44 алт, 32 мөнгө, 30 хүрэл медаль,
- Дэлхийн цэргийн аварга шалгаруулах /CISM/ тэмцээнээс 17 алт, 22 мөнгө, 29 хүрэл медаль,
- Найрамдалт армиудын спорт хорооны /СКДА/ тэмцээнээс 21 алт, 29 мөнгө, 34 хүрэл медаль,
- Олон улсын чанартай тэмцээнээс 306 алт, 478 мөнгө, 689 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлээд байна.





БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ-110 ЖИЛ

ЦЭРГИЙН ЯАМНААС ЯВАХ ЦЭРГИЙН ДҮРЭМ, ХЭМЖЭЭ ТОГТООЖ ДАГАЖ ЯВАХ ЯВДЛЫГ АЙЛТГААД БУУЛГАСАН ЗАРЛИГИЙГ СИЙРҮҮЛЖ МЭДЭГДЭН ИРСЭН ХЭРЭГ

Цэргийн явдлын яамыг 1911 онд байгуулсны дараа цэргийн хэргийн дүрмийг яаравчлан боловсруулан дайчилсан болон илгээсэн цэргийн дагаж явах түр дүрэм хэмээх 23 зүйлийг Богд хаанаар 1912 оны 12 дугаар сарын 28-нд айлтгуулсан.

Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны бичиг


Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаа өргөн илгээв.

Явуулах учир, Ноднин жил өвлийн сүүл сарын хорин зургаанаа манай Цэргийн яамнаас айлтгасан нь: Явах цэргийн дүрэм, хэмжээ тогтоож дагаж явуулах явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад:

Богд эзэн гэгээнээр толилохыг гуйхын учир, саяхан шавь боолчуудын газраас Хятад улсын цэрэг манай Монгол Улсын хязгаарын газар халдахаар ирсэн учирт таван зам хувааж, тосон сэргийлэх түшмэл цэргүүдийг мордуулах явдлыг тодорхойлж айлтгаад, зарлигаар явуулсныг хичээнгүйлэн дагаж, манай Цэргийн яамнаас зохих олон газар зарлан явуулан тушааж харьяат

Дарьганга зэрэг газрыг сэргийлэн хамгаалах, цэргийг бүгд захирагч дарга гүн Наваангомбо, Хоёр шөнөдийн зүг одуулах цэргийг бүгд захирагч дарга дэд сайд Насан-Ариовжих, Урд гурван гүнгийн дунд гүнгийн зүг одуулах цэргийг захирах түшмэл, зүтгэлт Егүзэр хутагтын зүг одуулах цэргийг захирах бэйсийн зэрэг Чимэгсэрэн, дэс түшмэл, Зоригт баатар гүн Тогтох, мөн цэргийг захирах хичээнгүй баатар гүн Найданжав нар, Ховд зүг мордуулах тайж Баярын харьяат цэргийг захирах тайж Өлзий-Орших нар, дэд зэрэг тайж Гончигжав, дэд зэрэг тайж Өлзий-Орших нарт хүргүүлэн явуулан тушаагаад уг айлтгаад, зарлиг тогтоосон хууль дүрмийг хичээнгүйлэн дагаж өөр өөрийн харьяалбаас зохих олон газар зарлан тушааж журамлан дагаж шийтгүүлэхээс гадна басхүү нижгээд хувь ёсоор сийрүүлж, Бүгд ерөнхийлөн захирах зэрэг таван яам, Егүзэр хутагт Галсандаш, Улиастайн хэргийг түр шийтгэх дэс түшмэл Сэцэн бэйс Жалцангомбоцэдэн, Дөрвөн аймгийн жанжин чуулганы дарга нар Шилийн гол, Улаанцавын чуулганы дарга нар, Дөрвөдийн зүүн баруун жанжин, чуулганы дарга нар, Хөвсгөл нуурын Урианхайн гүн Хишигжаргал, Дарьгангын бүгдийн тэргүүн гүн Сономдовдон нарт хүргүүлэн явуулан тушаагаад, байцаан хянан үзэж нэгэн лүгээ адил журамлан дагаж шийтгүүлсүгэй.

Үүний тул өргөн илгээв. Олноо өргөгдсөний гуравдугаар он цагаан сарын шинийн долоон, Зарлигаар тогтоосон Монгол Улсын Цэргийн яамны хууль зүйлийн бичгээс, Дайчлан мордуулсан цэрэгт чухал хэрэглэх зүйлийг сонгон сийрүүлж явах цэргийн хорооноо журамлан явахуйд



захирах түшмэл цэргүүдийг мордуулан буй бөгөөд үүнд шавь боолчууд хянан байцаахаас манай Монгол Улс тулгар төр нээн тогтоож харахан элдэв хууль зүйлийг тогтоогоогүй учирт аливаа дайчилсан ба элссэн цэргүүдэд дагаж явуулах дүрэм, хэмжээ огт үгүйн тулд, одоо Нийслэл Хүрэнээс Монголын зах хязгаарыг батлан хамгаалахаар гаргах цэргүүдийг хорио зохиож түшмэл байгуулах, захирлага, тэмдэг, туг, хиур, бүрээ, хэнгэрэг, харанга, урамдал олгуулах, орох, эргэх, зэвсэг хэрэглүүлэх, цэргүүдийг тоолон байцаах, хүрсэн газарт хүнсний хонь мал худалдан авах, элдэв хүнд хөнгөн ял халдагсдыг цээрлүүлэн шийтгэх зэрэг дүрэм хэмжээ бүгд хорин гурван зүйлийг бүгдээр зөвлөн хэлэлцэж хянан зохиож тогтоосон нь нийлэлцэх эсэх явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж уг зохиосон дүрэм хэмжээний хамтаар дээр давшуулан айлтгаад:

Богд эзэн гэгээнээр толилж, заалхийлэн сургаж дагаж явуулах ажаамуй, үүний тул хичээнгүйлэн айлтгав, зарлигийг гуймой хэмээн айлтгасанд, мөнхүү сарын хорин наймнаа хүлээн авсан уг нугалбарт улаан бийрээр цохсон, зарлиг нэмэх зүйлийг улаан бийрээр цохвой, бусдыг уг гуйсан ёсоор болгогтон хэмээснийг хичээнгүйлэн дагаж явах цэргийн дүрэм, хэмжээ тогтоож дагаж явуулах нугалбар ба зарлигаар нэмсэн зүйлийг бүрнээ тусгай сийрүүлж, үүнийг Баруун хязгаарыг батлан тохиулах сайд, хутагт, Хөлөн буйрын сайдууд, Өмнө хязгаарыг сэргийлэн хамгаалах, цэргийг бүгд захирагч сайд, гүн Сономдорж,

бэлтгэв.

Хороо байгуулахуй нь:

Нэгэн зүйл. Нийслэл Хүрээний газраас Монголын зах хязгаарыг батлан хамгаалахаар гаргасан цэргүүдийг бүрнээ хуваан хороо зохиож, хоёр зуун эрийг нэгэн хороо болгож байгуулагтун.

Түшмэл байгуулахуй нь:

Нэгэн зүйл. Арван цэрэг тутам арван дарга нэгжгээд, тавин цэрэг тутам ангийн дарга нэгжгээд, хороо тутам хорооны дарга нэгжгээд, жич хорооны жагсаалын түшмэл нэгжгээдийг гаргаж тус тус байгуулагтун.

Нэгэн зүйл. Аравны дарга нарыг ангийн түшмэл талби, ангийн түшмэдийг цэргийг бүгд захирагч даргын газраас сонгон талбиад цэргийн яамнаа мэдүүлэгтүн.

Захирлага тэмдэг олгуулахуй нь:

Нэгэн зүйл. Хорооны дарга нарт модон тэмдэг нэгжгээдийг сийлүүлэн олгуулахаас гадна бүгд захирагч дарга нарт олгуулах гуулин захирлага нэгжгээдийг цэргийн яамнаас, зарлигийг гуйн айлтгаад тус тус цутган олгуулагтун.

Туг хиур байгуулахуй нь:

Нэгэн зүйл. Бүгд захирагч даргад шар өнгийн их туг нэг, хорооны дарга нарт шар өнгийг дундаас бага туг нэгжгээд, ангийн түшмэл нарт бага туг нэгжгээд, тугийг дөрвөн зэрэг хэмжээ болгон хувааж их багыг үзэж дэс дараалан өөр өөрийн өнгөөр хэрэглэн аравны дарга нарт хиур нэгжгээдийг олгож өөр өөрийн өнгөөр тус тус хэрэглүүлэгтүн.

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт)

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН НЭГЖҮҮДЭД ҮҮРЭГ ЧИГЛЭЛ ӨГЛӨӨ

(Түрүүч нь I нүүрт)

Уулзалтын төгсгөлд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр бие бүрэлдэхүүнд хандаж үүрэг чиглэл өглөө. Тэрээр хэлэхдээ "Миний бие Батлан хамгаалахын сайдын албан тушаалд томилогдсоноос хойших хугацаанд БХЯ, Зэвсэгт хүчний хяналт шалгалтын нэгжүүдийн үйл ажиллагааг хуулийн дагуу, үр дүнтэй явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна. Энэ хүрээнд хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж үр дүнг нь дээшлүүлэх, дотоод аудитын үйл ажиллагааг тогтворжуулах, төсөв, санхүүгийн сахилга хариуцлагатай холбоотой зөрчил, дутагдлыг арилгах, таслан зогсоох, дотоод хяналтыг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлаар энэхүү уулзалтыг зохион байгуулж байна.

Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч болон хяналт шалгалтын нэгжүүдэд нэгдсэн удирдлага, зохион байгуулалт байхгүй, ажлын уялдаа холбоо хангалтгүй, чиг үүргийн зааг ялгаа тодорхойгүй, эрх зүйн зохицуулалт дутмаг зэрэг сул тал их байсан. Засгийн газрын 2020 оны 58 дугаар тогтоолоор Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн ажлын нэгж, түүний үндсэн үүрэг батлагдсантай холбогдуулан салбарын дотоод

аудит, санхүүгийн хяналт, шалгалтыг нэгдсэн төлөвлөгөө, зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин шинээр бүрдээд байна. Тиймээс шударга, ёс зүйтэй, хариуцлагатай, идэвхтэй үйл ажиллагааг дэмжин ажиллаж хоорондоо нэгдмэл зохион байгуулалттай ажиллах нь та бүхний үндсэн үүрэг юм.

Үүнтэй холбогдуулан дараах үүрэг, чиглэлийг өгч байна. Үүнд, хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг таниулах, сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж албан тушаалтнуудын мэдлэг ур чадварыг байнга дээшлүүлэх ёстой. Мөн зэвсэг, техник, галт хэрэгсэл, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, тэдгээрийн бүрэн бүтэн байдал, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулан улирал бүр хяналт явуулж бүртгэл тооцоог чанаржуулах шаардлагатай.

Анги, байгууллагуудын дотоод хяналт, шалгалтын ажлын хэсгийг мэргэжил арга зүйн өдөр тутмын удирдлагаар байнга ханган ажиллах ёстой. Иргэд, хуулийн этгээдийн үндэслэл бүхий мэдээллийн дагуу хийх хяналт шалгалтын үр дүнг нэмэгдүүлэхэд онцгой анхаарах нь чухал. Дээрээс нь батлан хамгаалах салбарын хяналт шалгалтын нэгжүүдийн хамтын ажиллагааг сайжруулан, хамтарсан ажлыг зохион байгуулах, мэдээлэл харилцан солилцох шаардлагатай"-г онцоллоо.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ОНЦГОЙ АНХААРАХЫГ ЧУХАЛЧЛАВ

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр энэ сарын 21-нд Батлан хамгаалах яам, харьяа агентлаг, байгууллагуудын өнгөрсөн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлантай танилцаж, энэ оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хяналаа. Батлан хамгаалахын сайдаар хянуулж буй 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан аргачлал, загвараар боловсруулж байгаагаараа онцлог юм.

Энэ үеэр сайд Г.Сайханбаяр "Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг, харьяа нэгжүүдийн удирдлагууд та бүхэнтэй хамтран ажиллах үндсэн чиглэл, бодлого, Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, сайдаас салбарын хэмжээнд хэрэгжүүлэх бодлогод нийцсэн энэхүү удирдлагын

гол баримт бичгийг хууль эрх зүйн шинэ орчинд нийцүүлэн шинэчлэн байгуулаа. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин нь Монгол Улсын хэмжээнд өргөн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. 2020 он мэргэжлийн шинэ Засгийн газар байгуулагдаж, шинэ бодлого, зорилго, зорилтоо тодорхойлохын сацуу өмнөх хийсэн ажлуудаа дүгнэж, цаашид юу хийх ёстойг тодорхойлсон чухал жил байлаа. Манай салбарын хувьд ирэх дөрвөн жилийн хугацаанд хийх ажлууд маш тодорхой. Тиймээс төсөвт байгууллагуудын удирдлагууд та бүхэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заагдсан арга хэмжээнүүдээ эхнээс нь чанартай гүйцэтгэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Батлан хамгаалах яамнаас та бүхний гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бүх талаас нь дэмжлэг үзүүлэн ажиллах болно" гэдэг ажлын амжилт хүсэн ерөөлөө.

АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ХУРАЛДААН БОЛЛО

БХЯ-наас ахмад настны талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дөрвөн жилийн төлөвлөгөөг өнгөрөгч онд баталж, Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Ахмадын зөвлөлийг байгуулсан юм.

Өнгөрөгч Даваа гарагт тус зөвлөлийн анхдугаар хуралдаан болж, энэ оны үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг батлан, Батлан хамгаалах яамны 110, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн түүхэн ойг тохиолдуулан зарим ахмадыг төрийн дээд цол, одон медалиар шагнах тухай саналыг хэлэлцлээ. Хуралдаанд Ахмадын зөвлөлийн дарга, чөлөөнд байгаа хошууч генерал Д.Магсаржав, БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын

дарга, хурандаа Ч.Гандирваа, БХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа Д.Ганбат, ЗХЖШ-ын Хүний нөөцийн хэлтсийн дарга, хурандаа Н.Гантөмөр, "Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв" ТӨААТҮГ-ын захирал, бэлтгэл бригадын генерал Д.Ганбаатар, ЗХЖШ-ын Ахмадын хорооны дарга, чөлөөнд байгаа хошууч генерал Д.Бадам, ҮБХИС-ийн Ахмадын хорооны дарга, бэлтгэл хурандаа Х.Батдэлгэр, ЦТЭ-ийн дарга, хурандаа С.Батболд, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч, хурандаа Т.Лодойдамба нар оролцож санал бодлого солилцсон бол хурлын төгсгөлд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр сайд Ахмадын зөвлөлийн гишүүдэд үүрэг чиглэл өгөв.

“МОНГОЛ ЦЭРЭГ-ТУСГААР ТОГТНОЛ” СЭДЭВТ ИДЭВХТЭН БИЧИГЧДИЙН БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Монгол Улсад Цэргийн явдлын яам буюу өнөөгийн Батлан хамгаалах яам байгуулагдсаны 110, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний "Соёмбо" редакцияас нийт идэвхтэн бичигчдийн дунд цэрэг-эх орны сэдэвт дараах уралдааныг зарлаж байна.

Нэг. Зорилго: Уралдаан нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын дархлаа, үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэх, Төрийн батлан хамгаалах бодлого, зорилтын хэрэгжилт, орчин цагийн Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, хөгжил дэвшил, түүхэн замнал, эх орны хөгжил цэцэглэлтэд оруулсан хувь нэмэр, цаашдын чиг хандлагын талаар нийгэмд үнэн бодит мэдээ мэдээллийг хүргэх, хүүхэд залуучуудад эх оронч үзэл, үндэсний бахархал, хүмүүжлийг төлөвшүүлэх.

Хоёр. Эхлэх он, сар, өдөр, хамрах хүрээ:

Уралдаан 2021 оны 2 дугаар сарын

1-нээс 12 дугаар сарын 1-ний хооронд явагдана. Өөрсдийн материалыг хэвлэн нийтлүүлэх сонирхолтой бүх насны иргэд, идэвхтэн бичигч оролцох боломжтой.

Гурав. Зохион байгуулагч: Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний "Соёмбо" редакция **Дөрөв. Тавигдах шаардлага:**

- Өгөгдсөн сэдвийг гол агуулгаа болгож баримтлах;
- Сэтгүүл зүйн дурсамж, хөрөг, нийтлэл зэрэг төрлүүдээр бичигдсэн байх;
- Шинэлэг мэдээ мэдээлэл, тоо баримт дурдагдсан байх;
- Чөлөөт сэтгэлгээ, бичлэгийн ур чадварыг илтгэсэн дүр дүрслэл сайтай байх;
- Ашигласан эх сурвалжуудаа иш татсан байх;
- Өмнө нь аль нэгэн сонин, сэтгүүлд нийтлүүлээгүй шинэлэг бүтээл байх;
- Microsoft Word програм ашиглан А4 хэмжээтэй хэвлэмэл хуудсан дээр Arial фонтоор, 12 үсгийн хэмжээтэй, зүүн захаас

2.5 см, дээд захаас 2 см, доод болон баруун захаас 1.5 см зайтайгаар бичсэн байх;

➢ Нэг хүн хэдэн ч материалаар оролцож болно.

Тав. Материалыг хүлээн авах, шалгаруулах журам:

Бичлэгийн уралдаанд ирүүлэх бүтээлийг цахимаар буюу Soyombo@mod.gov.mn хаягаар хүлээн авна. Шалгаруулалтыг 2021 оны 12 дугаар сарын 1-5-ны хооронд "Соёмбо" редакцияны сэтгүүлч, сурвалжлагчдаас бүрдсэн баг сонгон шалгаруулна.

Зургаа. Анхаарах зүйл:

- Товч танилцуулга, оршин суугаа хаяг, холбоо барих утасны дугаар, цахим хаяг зэргийг тодорхой бичиж хавсаргана.
- Шууд хуулбарласан, шаардлага хангаагүй материалыг шалгаруулалтад оролцуулахгүй.
- Шалгаруулалтад ирүүлсэн шилдэг бүтээлийг "Соёмбо" сонин, "Эх орны төлөө"

нэвтрүүлэг, цахим сүлжээ болон бусад хамтран ажилладаг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилж, БХЯ-ны 110, Зэвсэгт хүчний 100 жилийн ойд зориулсан "Соёмбо" редакцияны эмхэтгэлд нэг болгон хэвлүүлж, олон нийтийн хүртээл болгоно.

Долоо. Шагнал, урамшуулал:

- Нэгдүгээр байр нэг, Өргөмжлөл, мөнгөн шагнал, "Соёмбо" редакцияны хэвлэмэл эмхэтгэл 1 хувь.
- Хоёрдугаар байр нэг, Өргөмжлөл, мөнгөн шагнал, "Соёмбо" редакцияны хэвлэмэл эмхэтгэл 1 хувь.
- Гуравдугаар байр нэг, Өргөмжлөл, мөнгөн шагнал, "Соёмбо" редакцияны хэвлэмэл эмхэтгэл 1 хувь.
- Эхний 9 байр эзэлсэн оролцогчийг "Соёмбо" сонин 2022 оны захиалгын эрхээр тус тус урамшуулна.

БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ "СОЁМБО" РЕДАКЦ



(Түрүүч нь I нүүрт)

Салааны захирагч, залуухан офицер байхдаа Батлан хамгаалах яамны жуух бичгээр шагнуулж байжээ ...

-Би долоон жил салааны захирагч хийсэн. 1953 онд Дорнод аймгийн Чойбалсан хотод байсан зэвсгийн складад каминдант, салааны дарга, мөн маршал Х.Чойбалсангийн нэрэмжит морьт суманд танк эсэргүүцэх их бууны салааны дарга зэрэг албан тушаалд ажиллаж байлаа. Энэ хугацаанд нэгэн онцлох үйл явдлын гэрч болсон юм. ЗХУ болон БНМАУ-ын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн дагуу БНАСАУ-д бэлгийн агт морьдыг хүргүүлэх тухай Сайд нарын зөвлөлийн тогтоол гарч байлаа. 1954 он шиг санагдаж байна, би тэгэхэд дэслэгч цолтой байсан юм. Ахлах дэслэгч н.Дарьжав болон дэслэгч Б.Арслан миний бие агт морьдыг хүргүүлэх хүндтэй үүргийг хүлээж билээ. Ингээд залуухан салааны дарга нар 25 цэргийн хамтаар

хурандаа Ц.Даваажав гэсэн бүрэлдэхүүнтэй оролцож байлаа. Дараа жил нь мөн тус сургуульд Монгол Улс оролцсон. Би хоёр дахь удаагаа тус сургуульд оролцождоо хэд хэдэн удаа илтгэл тавьсан. Ерөнхий цэргийн тавдугаар армийн хувьд байлдаанд цөмийн зэвсэг хэрэглэсэн ба хэрэглээгүй нөхцөлд оперативын болон дэмжих ажиллагааг хэрхэн хийх вэ гэх зэргээр. Их ч зүйл ойлгуулсан, цөөнгүй хүн хүч, зэвсэг техникийг оролцуулсан нүсэр сургууль гэж боддог.

Таны хувьд шат шатны албан тушаалд меритийн зарчмаар дэвшиж ажилласан. Алба хаасан эдгээр он жил танд юуг хамгийн их ойлгуулсан гэж боддог вэ?

-Цэргийн даргыг цэрэггүйгээр төсөөлөх аргагүй. Тиймээс цэрэгтэйгээ ойр байж, ойлгохыг хамгийн их эрмэлздэг байлаа. Тэр цэрэг хэн байх нь, ямар байх нь тийм ч чухал биш. Оршил болгож хэлэхэд, салааныхаа цэргүүдтэй цуг Халх голын районд сар гаруйн хугацаагаар хадлан хадаж, Чойбалсан хотын Бунхан толгойд байсан Армийн зэвсгийн



Б.Арслан: МЯНГАН АГТЫГ САР ГАРУЙН ХУГАЦААНД ТУУСААР МАНЖУУРТ ХҮРГЭЖ БАЙЛАА

1000 агтыг Чойбалсан хотын Хэрлэнцагаан талбайгаас бэлчээрийн аргаар сар гаруйн хугацаанд туусаар одоогийн БНХАУ-ын Манжуур хотод хүргээд хүлээлгэн өгч байлаа. Тэндээс БНАСАУ-ын холбогдох албаны хүмүүс вагоноор ачаад авч явсан. Тэр үед би нэг зүйлийг ойлгож авсан юм. Вагонд ачихаас өмнө хэд хэдэн адуу сүргээсээ тасарч нутгийн зүг давхих гэж оролдсон. Зөнгөөрөө нутаг руугаа тэмүүлдэг юм билээ. Би ч бахархах, өрөвдөж хайрлахын аль аль нь болсон. Эх орон, эх нутгаа гэх үзэл, ойлголт адгуусанд хүртэл нэвт шингэсэн байдаг нь сонин юм шүү.

Дараа нь 1956 онд Батлан хамгаалах яамны сайдын тушаалаар Хужирбулан дахь зэвсэг, галт хэрэгслийн складад зэвсгийн техникчээр томилогдон жил ажиллаад, 1957 оноос тухайн үедээ цор ганц Артиллерийн дивизэд удирдах салааны даргаар 1960 он хүртэл алба хаасан. Салааны даргаар ажилласан долоон жилд арми их цомхон байж. 1945 оны Чөлөөлөх дайны дараахан Монгол Улс батлан хамгаалах зардлаа маш ихээр танаж хорогдуулсан. Зэвсгийнхний хувьд ч өөр ажил, албан тушаалд томилогдох боломж бололцоо хомс байсан юм байлгүй. Энэ мэт шалтгаанаас болоод салааны даргаар долоон жил ажилласан байж. 1955 онд Морьт суманд танк эсэргүүцэх салааны даргаар ажиллаж байх үед Ардын Армийн Жанжин шатбын шалгалтын комиссынхон ирсэн. Шалгалтаар миний удирдсан салаа "Тэргүүний салаа"-ны болзол хангаж байлаа. Би ч Дорнод аймгийн ХЗЗ-ийн тэргүүлэгчээр шалгарч, МХЗЗ-ийн XII дугаар их хуралд Дорнод аймгаа төлөөлж оролцсон тохиолдол бий. Салааны даргаас цааш дивизионы штабын туслах хийж байгаад 1966 онд ЗХУ руу академид суралцахаар явж билээ.

Тэр жуух бичиг гэлтгүй төрийн хайр хийшгүй их хүртсэн дээ. Төрийн дээд шагнал Сүхбаатарын одон, Байлдааны медаль, Байлдааны гавьяаны одон, Байлдааны гавьяаны улаан тугийн одон, бусад ойн медаль гээд. Энэ бүхний ард үүрэг хариуцлага нэмэгддэг шүү гэж өөртөө хэлдэг байлаа.

Тухайн үеийн Офицерын сургууль танд ямар дурсамж үлдээсэн бэ?

-Бараг 700, 800 шахам эрэгтэй сурагчтай, хагас бүтэн сайнгүй биеийн тамир, маршийн бэлтгэл гээд завгүй. Одоогийн Офицеруудын ордонд бүхэлдээ хичээлийн танхим байрладаг байв. Дотуур байр нь одоогийн Батлан хамгаалах яамны барилга. Хойноо маш том талбайтай байсан. Тэнд янз бүрийн биеийн тамирын арга хэмжээ болно. Миний хувьд биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг идэвхтэй, ойр давтамжтай хийж, маш их хичээл зүтгэл гаргасан. Үүний хүчинд өнөөдөр надад даралтаас өөр архаг хууч хэлбэр их тарж газар авсан шиг байгаа юм. Ингээд 1984 онд Зүүн Азийн социалист орнуудын Зэвсэгт хүчнүүдийн хамтарсан команд штабын сургууль Улан-Үдэд зохион байгуулагдсан. Тухайлбал, Монгол, ЗХУ, Вьетнам, Лаос гэсэн дөрвөн орны Зэвсэгт хүчин оролцсон. Сургууль Улан-Үдэ хотын урдуур урсдаг голын дэнжид болж, Монголын талаас Батлан хамгаалах яамыг төлөөлж Ардын Армийн Жанжин штабын дарга, дэслэгч генерал Ч.Пүрэвдорж биднийг даргалж, Ерөнхий цэргийн командлалын тавдугаар Армийн командлагч, хошууч генерал Д.Гэндэнпил, штабын дарга, хошууч генерал Т.Баатар, Артиллерийн командлагч, хурандаа Б.Арслан, штабын дарга, дэд

складын хэрэгцээгүй болсон зарим галт хэрэгслийг аюулгүй болгож, устгах ажилд 20-иод хоног үүрэг гүйцэтгэж байсан. Энэ үед хүнийг яаж ажиллуулах, урамшуулах, итгэлийг нь хэрхэн олж авах, бас тийм дайны итгэлийг хүлээлгэх гээд цаашид ажил албандаа хөрс болгох олон зүйлийг олж авсан. Товчхондоо хүнтэй яаж ажиллах вэ гэдэг арга барилд суралцсан гэж болно. Дараа нь Зэвсэгт хүчний 120 дугаар ангид томилогдож, захирагчаар нь таван жил ажиллахдаа цэргийн алба хаагчаас гадна энгийн ажилчидтай хэрхэн харилцах вэ гэдэг шинэ асуултын хариултыг олох гэж их хичээсэн. Боловсролтой, боловсролгүй, хөгшин, залуу гээд янз бүрийн л хүмүүс байсан. Цэргийн ёсонд шууд захирагддаггүй тийм хүмүүстэй ажиллах нэг ёсондоо сорилт байлаа. Бас л хүнийг ойлгох арга ухаанд сургаан хамт олон байв. Одоо санахад Зэвсэгт хүчний 120 дугаар ангиас угшилтай хурандаа Л.Төмөр, н.Нямсүрэн гэж сайн дарга нар ч байж. Тэд маань ёстой л өөрсдөө үлгэрлэцгээдэг, бага ярьж их хийцгээдэг байсан гэвэл яг таарна.

Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн байр зүйн зургийг баталгаажуулахад таныг оролцсон гэдэг. Боломж олдсон дээр нь өөрөөс тань сонсьё гэж бодлоо ...

Цэргийн даргыг цэрэггүйгээр төсөөлөх аргагүй. Тиймээс цэрэгтэйгээ ойр байж, ойлгохыг хамгийн их эрмэлздэг байлаа. Тэр цэрэг хэн байх нь, ямар байх нь тийм ч чухал биш. Оршил болгож хэлэхэд, салааныхаа цэргүүдтэйгээ цуг Халх голын районд сар гаруй хугацаагаар хадлан хадаж, Чойбалсан хотын Бунхан толгойд байсан Армийн зэвсгийн складын хэрэгцээгүй болсон зарим галт хэрэгслийг аюулгүй болгож, устгах ажилд 20-иод хоног үүрэг гүйцэтгэж байсан. Энэ үед хүнийг яаж ажиллуулах, урамшуулах, итгэлийг нь хэрхэн олж авах, бас тийм дайны итгэлийг хүлээлгэх гээд цаашид ажил албандаа хөрс болгох олон зүйлийг олж авсан. Товчхондоо хүнтэй яаж ажиллах вэ гэдэг арга барилд суралцсан гэж болно.

-Би 1962 онд Батлан хамгаалах яамны Их бууны хэлтэст их бууны тагнуулын офицероор ажиллаж байлаа. Тэр жил ЗХУ-аас Батлан хамгаалах яамны шугамаар уригдаж ирсэн байр зүй, геодезийн мэргэжилтэн П.С.Осейнин гэж ахмадтай хамт одоогийн Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд очлоо. Түүний хамтаар Сургалтын нэгдсэн төвийн зурвасыг байр зүй, геодезийн хувьд баталгаажуулахаар боллоо. Ингээд Сургалтын нэгдсэн төвийн газар орны зургийг нарийвчлан гаргаж, урд, хойд, баруун, зүүн захыг нь тогтоож, байр зүй, геодезийн хувьд албан ёсны болгосон. Үүний үндсэн дээр тухайн үеийн Монгол Улсын Сайд нарын зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал, Батлан хамгаалах яамны сайд, армийн генерал Б.Дорж нар холбогдох тогтоол гаргасан. Ингэснээр иргэд болон мал амьтан Сургалтын нэгдсэн төвийн бүс рүү ажиж нэвтрэхгүй болж, тодорхой эрсдэлээс сэргийлэгдсэн гэж хэлж болно. Бүр агаарын орон зайд хамаарах асуудлуудыг нь зохицуулж өгсөн. Энэ талаар би өөрөө нэг их ам нээдэггүй болохоор мэдэх хүн ховор. Бичиж тэмдэглэсэн зүйл ч бас алга. Тэр үеийн дарга нар ч бурханы оронд одож дээ.

Тийм учиртай байж. Цэргүүдгүйгээр цэргийн даргыг төсөөлөхгүй гэж хэлсэн дээ. Сайн дарга гэдэг мэдэрсэн тийм үе, дурсамжаа эргэн санавал ...

-Зэвсэгт хүчний 120 дугаар ангид байхад болоод өнгөрсөн дурсамжтай үе бий. Ер мартдаггүй юм. Манай ангид Авдалхан гэж

казак цэрэг алба хаадаг байлаа. Тэр цэрэг нэг өдөр өрөөнд яаран гүйж орж ирлээ. Тэгээд "Нөхөр дэд хурандаад илтгэе" гэж байна. Үргэлжлүүлээд нэг бичиг цаас үзүүлж байх юм. Авдалханы ээж нь өөд болсон учир түүнд чөлөө олгохыг хүссэн албан бичгийг аймгийнх нь Цэргийн хэлтэсэс ирүүлсэн байв. Хүний л амьдрал юм хойно юу эс тохиолдох билээ дээ, таашгүй. Тэгэхээр нь долоо хоногийн чөлөө цохоод өгсөн. Хэсэг хугацааны дараа өнөөх Авдалхан дахиад ороод ирлээ. Чи чинь яваагүй байсан юм уу гэтэл Авдалхан нэг зүйл хэлэх гээд бувтнаад байна. Би ч "За алив юу болсон юм, даргадаа хэл" гэлээ. Авдалхан нисэх онгоцны буудал орох, бас онгоцны билет авах мөнгөгүй гэдгээ учирлалаа. За "Нөхөр минь, түр хүлээж бай, энэ асуудлыг чинь шийдэж өгнө" гэж хэлээд гаргасан. Тэр үед надад мөнгө байсангүй, тэгсэн мөртлөө өнөөх цэрэгтээ ам гарчихсан. Харин эхнэр рүүгээ залгаж мөнгө асуусан нь оносон юм. Ингээд Авдалханд зардлын мөнгө өгөөд, ангийн унаагаар онгоцны буудал руу хүргэж өглөө. Долоо хоногийн чөлөө аваад явсан нөхөр 10 хоног боллоо. Яав ийв гэж байтал 10 дахь хоногтоо ангидаа ирэх нь тэр. Тэгээд бас нэг бичиг цаасархуу юм үзүүлж харуулах бололтой. Ховд аймгийн Цэргийн хэлтэсээс

тэтгэвэртээ гарсан. Тэр үед одоогийнх шиг 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж байсангүй. Сүүлийн сарын цалингаа аваад ангийн хашаанаас гарсан.

Одоо бодоход цэргийн дарга байсан цаг хугацаа намайг хүнийг ойлгох, хүнтэй харилцахад гайгүй сайн сургаан. Тэтгэвэрт гарсны хойно гэртээ удаан суугаагүй. Хэрэв удсан бол ёстой гиеүрэх байсан байх. Би уламжлалт анагаах ухаанаар мэргэшсэн, бариа засал, эмчилгээ хийдэг ухаантай. Монголд анх удаа "Оточ-Манал" анагаах ухааны эмнэлэг байгуулагдахад нь би урилгаар очиж ажиллаж байлаа. 1989 оноос хойш уламжлалт анагаах ухааны эмчилгээ хийсээр байна. Олон ч аймаг сумаар явсан. Армид байхдаа өвдөж, хавдсан цэргүүдээ эмчлээд тордчихдог, хааяа уул хадаар явж эмийн ургамал түүдэг байсан. Артиллерийн генерал, хурандаа нар андахгүй дээ. Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд артиллерийн ангиуд гарчихсан байгаа үед би харагдахгүй удвал Б.Арслан хурандаа өвс ургамалдаа явчихсан биз гэж ярьцгаадаг байсан гэнэ лээ. /Инээв/

1991 онд эмчилгээ хийх эрхээ Эрүүл мэндийн яамнаас авсан. Өөрөөр хэлбэл, бариа засал хийх, онош тавих, эмчлэх эрх өгсөн гэсэн үг. Өнөөдөр ч гэсэн судас барих, онош тавих, өвчний түүх нээх, эм барих, эмчилгээ хийх, эмнэн эдгээх гээд сурсан эрдмийнхээ хэргийг гаргаж л байна.

Өмнөх нийгмийн үед тийм хүмүүс цөөн байсан. Тийм чадвартай байсан ч түүнийг ил гаргаад байгаагүй гэлцдэг?

-Хэнтий аймгийн Өндөрхааны бага сургуульд байхдаа бариа засал хийдэг увидастай нэгэн ламын гар дээр хэдэн жил болсон юм. Тэр үеэс л эхэлсэн. Тухайн үед Офицерын сургуульд ороход ямар анкет бөглөдөг байсан бэ гэвэл их сонин. Овог нэр, яс үндэс, үүсэл гарал, өөрөө болон ах дүү, төрөл төрөгсөд дунд нь лам хуварга байсан эсэх гээд бүгдийг бүртгэдэг байсан. Тиймээс надад багадаа лам хүний гар дээр байсан гэж хэлэх эрх байгаагүй. Хожим Эрүүл мэндийн яамнаас эмчилгээ хийх эрх, зөвшөөрөл авах гээд хурлаар орохдоо энэ талаараа ярьсан. Хаана, хэзээ, хэрхэн уламжлалт анагаах ухааны эмчилгээ хийх арга барилд суралцсан гэдгийг тухайн үеийн Эрүүл мэндийн дэд сайд нь асууж лавлаж байсан. Багадаа тэгсэн, ингэсэн гээд хариулсан. Өмнө нь энэ талаараа ам нээж, авиа ч гаргаж үзээгүй. Армид бол бүр ч болохгүй байсан.

Гэр бүлээ товч танилцуулахгүй юу?

-Би хожуу гэрлэсэн хүн. 1958 онд Б.Чимэдцэрэн гэж бүсгүйтэй танилцаж, гэр бүл болж байлаа. Ханилаад 60 гаруй жилийн нүүрийг үзэж байна. Хөгшин маань Зэвсэгт хүчний 032 дугаар ангиас тэтгэвэртээ гарсан. Гал голомтоо бадрааснаас хойш 10 сайхан хүүхэд төрүүлж, бид хоёр гарыг нь ганзаганд, хөлийг нь дөрөөнд хүргэлээ. Дөрвөн хүү, зургаан охин бий. Тэд маань үр хүүхдүүдтэйгээ Америк, Канад, Улаанбаатар болон Хэнтий аймаг зэрэг газар энх тунх аж төрж байна.

Хэн нэгнийг нь цэргийн мэргэжлийн хүн болгоё гэж шахаагүй юм байна, тийм үү?

-Тийм хүсэл огт байсангүй. Хүүхдүүд ч их хожуу төрцөгөөсөн. Хоёр нь цэргийн алба хаасан. Хуучин Улиастайн дивизэд засварын авто батальон гэж байхад том хүү маань тэнд ахлагч цолтой алба хааж байсан. Цомхотголоор халагдчихсан юм. Нөгөөх нь Зэвсэгт хүчний 120 дугаар ангид хугацаат цэргийн алба хаасан. Прокурорын байгууллагад ажилладаг дэд хурандаа цолтой охин бий. Ер нь өөрсдөө л хүсэж, зорьсон ажил албаа хийж явна. Үр хүүхдүүд маань эрүүл саруул явахаас өөрөөр хүсэх зүйл надад байхгүй.

Энэ онд Батлан хамгаалах яамны 110, Зэвсэгт хүчний 100 жилийн ой тохионо. Өөрчлөлт хувьслынх нь түүхийн гэрч болсон хүний хувьд Зэвсэгт хүчний өнөөгийн байдал, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг хэрхэн хардаг вэ?

-Алба хаагчдын маань эрх зүйн орчин сайжирч, нийгмийн хамгааллын асуудал нь тодорхой түвшинд шийдэгддэг болсон гэж боддог. Олон сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж авдаг гэдгийг өмнө нь хэлсэн. Хөндөж гаргаж ирсэн хамгийн чухал асуудал орон байрны асуудал. Хуучин цагт анги, аймаг дамжиж явсаар эцэст нь хоосон хоцорсон цэргийн алба хаагчид олон. Тиймээс Батлан хамгаалах яам сүүлийн жилүүдэд энэ асуудалд анхаарал хандуулж, шийдэхийн тулд тодорхой бодлого барьж ажиллаж байгаа байх. Саяхан л гэхэд Батлан хамгаалахын сайдын тушаалаар алба хаагчдад хөнгөлөлттэй үнээр орон сууц олгосон. Би үүнийг тун зөв зүйл гэж хардаг. Бас боловсон хүчин маш сайн шинэчлэгдэж, батлан хамгаалах чадавч сайтар бэхжиж байна.

1990-ээд онд УИХ-ын зарим гишүүд Монгол Улс Зэвсэгт хүчинтэй байх шаардлагагүй гэсэн тун хариуцлагагүй үгсийг амнаасаа унагасан. Тусгаар тогтносон бүрэн эрхт улс Зэвсэгт хүчинтэй байх нь зүйн хэрэг. Бас энхийн сахиулагчдын талаар ярих нь зөв байх. Бид тэднийхээ ажил, албыг маш сайн ойлгох хэрэгтэй. Энхийг сахиулж ирээд нийгмийн баталгаагаа тодорхой эмжээнд хангаж байгаа нь сайшаалтай. Гэхдээ тэд дэлхийн халуун цэгт ямар хариуцлагатай үүргийг гүйцэтгэж, улс орныхоо нэр хүндийг хэрхэн өндөрт өргөдөг вэ гэдэг талаар эргэцүүлж бодоорой гэж хэлжэе. Бид хэдэн бор цэргүүдээ хайрлаж, ажил албыг нь ойлгож, хүндэлж байх хэрэгтэй гэж хэлмээр байна. Тэд чинь энэ цагийн эгэл баатрууд юм шүү дээ.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ



ДЭЛХИЙН ШИЛДЭГ ТУСГАЙ ХҮЧНҮҮД СУРГАЛТ БЭЛТГЭЛЭЭ ХЭРХЭН ЯВУУЛДАГ ВЭ

(Түрүүч нь I нүүрт)

АНУ

АНУ-ын Тусгай хүчнийхний ногоон берет малгайгаар нь төвөггүй таньж болдог. Тэнд элсэхийн тулд заавал Тусгай хүчний үндсэн курсэд суралцах ёстой. Энэхүү курс нь 53 долоо хоногийн турш үргэлжлэх зургаан шаттай хөтөлбөрөөс бүрддэг. Элсэхийн өмнө эрүүл мэндийн үзлэг, биеийн тамирын сорил өгч, тэнцвэл сонсогч нь дараачийн шатанд өгсөх замаар суралцдаг.

Нэгдүгээр шатанд долоо хоногийн хугацаатай АНУ-ын Тусгай хүчний түүх, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтын талаар танилцуулга орно. Мөн сургалтын ерөнхий зорилго, үр дүнг танилцуулж, жижиг бүлгийн ажиллагааны арга, тактикийн танилцаж, хосолмол (hybrid) дайн, байлдааны тактикт суралцдаг. Үндсэн курсийн бэлтгэлийн эхэнд 19 өдрийн хугацаатай байр зүйн баримжаа, газрын зурагтай ажиллах, зүг чиг олох мэдлэгийг байгаль цаг уурын хүндрүүлсэн нөхцөлд хүнд ачаатайгаар өдөр, шөнийн маршаар тогтоосон хугацаанд туулах чадварыг эзэмшүүлдэг аж. Маршийн хугацаанд төрөл бүрийн цагийн байдалд шийдвэр гаргах, багаар ажиллах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх зэрэг чадварыг давхар олгодог. Дараа нь ажиллагааны төлөвлөлт гаргах, шүхрээр буух, буудлагын дасгал сургуулиудыг боловсруулдаг.

Хоёрдугаар шатанд сонсогчдын англи хэлний түвшинг тогтоож, дөрвөн шатлалд хуваадаг. Нэгээс хоёрдугаар түвшинд багтсан сонсогч 18 долоо хоног, 3-4 дүгээр шатлалд багтсан нь 24 долоо хоногийн тусгай хүчний хэрэгцээний англи хэлний сургалтад тус тус хамрагдаж, ярих, унших, сонсох чадварт суралцдаг байна.

Гуравдугаар шатанд жижиг бүлгийн ажиллагааны тактикийн хичээлүүд багтдаг. Тус шатанд



5 долоо хоногийн хугацаатай тактикийн байлдааны бэлтгэл, гардан тулааны сургалтууд ордог. Үлдсэн хугацаанд газар орны үнэлгээ хийх, гар хийцийн тэсрэх бөмбөгийг таних, амьд гарах арга ухаан, гавлагдсан, хүлэгдсэн зэргээр хөдөлгөөнөө хориулсан үед зугтах арга техник суралцдаг. Ингээд сургалтын төгсгөлийн тав хоногт танхимын сургалтаар олж авсан мэдлэгээ дадлагын цагийн байдалтай уялдуулсан сорилт өгдөг.

Дөрөвдүгээр шат нь 14 долоо хоног үргэлжлэх бөгөөд өмнө нь олж авсан мэдлэгтээ тулгуурлан команд штабын түвшинд хэрхэн ажиллах, асуудалд дүн шинжилгээ хийж, шийдлийн гарцыг богино хугацаанд олох, манлайлах чадварыг сургагч багш нар сонсогчдоос шаардана. Түүнчлэн дэлхийн өнцөг булан бүрд хаана ч очиж үүрэг гүйцэтгэх чадварт суралцан, улс орнуудын соёл, зан заншилтай танилцдаг.

Тавдугаар шат нь "Robin Sage" буюу уламжлалт бус хосолмол (hybrid) дайн, байлдааны арга, ажиллагааны тактикийг дадлагын полигонд бодит мэт цагийн байдалтай уялдуулан суралцахыг хэлнэ. Сонсогчдоод энэ нь маш чухал сургалтын үе бөгөөд жил гаруйн хугацаанд олж авсан мэдлэг, дадлагаа харуулах

эцсийн сорил юм. Цэргийн болон иргэний сайн дурын туслах ажилтнууд энэхүү сургалтыг дэмжиж, эсрэг дүрд тоглодог. "Robin Sage" сургалтыг энгийн иргэдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж зохион байгуулдаг. Учир нь хот дотор сургалтын байлдааны ажиллагаа явагддаг учир иргэдийн хөдөлгөөнийг шууд хорьж, тэдний эд хөрөнгөд онцгой анхаарал хандуулж ажиллахыг шаарддаг. Сургалтын үеэр ашигладаг сургалтын талбай, тээврийн хэрэгслүүд нь тодорхой таних тэмдгээр ялгагдана.

Зургаадугаар шат нь долоо хоног үргэлжилнэ. Сургалтын хугацаанд таван шатлалыг амжилттай төгсөж, шигшигдсэн сонсогчдод ногоон берет малгай өмсүүлэх ёслол болдог. Сонсогчид Тусгай хүчний үндсэн сургалтыг амжилттай төгсөөд шүхэрт десантын, байлдааны шумбалтын, тусгай хүчний мэргэн буучдын зэрэг сонирхсон бүх чиглэлээрээ үргэлжлүүлэн суралцахад нээлттэй байдаг. Нөгөөтэйгүүр тусгай хүчний цэрэг нь бусад бүх төрлийн цэрэгт ажиллагааны үндсэн мэдлэг, дадлага олгох, багшлах эрхийг эзэмшдэг. АНУ-ын бусад холбоотон улсаас санал болговол тусгай ажиллагааны бэлтгэл сургалтыг гардан зохион байгуулах чадвартай байдаг.

Их Британи

Их Британийн Тусгай хүчний цэргийн хувьд шаргал берет малгай өмсдөгөөрөө бусад цэргүүдээсээ ялгардаг. Ийм малгай өмсөхийн тулд тусгай ангийн гурван бүрэлдэхүүнд хоёроос дээш жил алба хаасан, 30-аас доошгүй настай байх ёстой. Өөрөөр хэлбэл, Эзэн хааны Агаарын цэргийн 22 дугаар тусгай алба, Агаарын цэргийн үйлчилгээний тусгай нөөц, Байлдааны завины хороо зэрэгт алба хаадаг цэргүүдэд элсэлт байдаг. Сонгон шалгаруулалтыг өвөл, зуны улиралд жилд хоёр удаа явуулдаг. Тэнцсэн тохиолдолд байлдааны усан сэлэлт, тусгай ажиллагааны тактик, сэтгэл зүйн бэлтгэлд хамрагдана.

Эзэн хааны Тэнгисийн цэргийн Тусгай хүчинд нэгдэхэд эрүүл мэнд болон оюун ухааны шалгуур үзүүлэлтийг маш нарийн тооцдог. Элсэгчдийн дийлэнх нь энэ шалтгаанаар хасагдах тохиолдол түгээмэл. Эрүүл мэндээр тэнцсэн ч заавал биелүүлэх ёстой биеийн тамирын сорилуудтай тулгарах болно. Шотландын алслагдсан Дартмүүр цэргийн баазад анхан шатны сургалтын эхний хэсэг 8 долоо хоногийн турш

үргэлжилнэ. Үүнд хүч чадал, мэдрэмж, тэсвэр тэвчээрийг бий болгодог аэробикийн дасгал, хөдөлгөөнүүд багтана. Холын зайд гүйх хоёр янзын гүйлтийн дасгал болох тогтмол хурдаар тасралтгүй, жигд бус хурдаар амралттай хол зам туулах чадварыг эзэмшүүлнэ. Ингэхдээ цаг агаарын болон газар орны онцлогт тохирч, хүн нэг бүрийн хэрэгсэлтэй гүйнэ. Дараагийн хэсэгт газар орны байршил тогтоох, ууланд авирах, бүслэн нэгжих ажиллагаа, эмнэлгийн тусламж үзүүлэх сургалтууд хэрийн нөхцөлд явагдана.

Түүний дараа Зүүн Өмнөд Азийн оронд ширэнгэн ойд байлдааны ажиллагаа явуулах сургалтад хамрагдаж, амьд гарах арга ухаан, ширэнгийн хурдан буудлага, сэтгэл зүйн тэсвэр тэвчээр зэрэг олон төрлийн сургалтад хамрагдана. Бүлэг тус бүр хязгаарлагдмал хүнсний хангалтаар хоёр долоо хоногийн турш тодорхой хугацаанд заасан цэгт явганаар хүрч очих ёстой. Энэ хэсэг нь ширэнгэн ойн сургалтын хамгийн хүнд хэсэг байдаг. Анхан шатны сургалтын хугацаанд сонсогчид шалгалтад нэг удаа унаж болно. Хоёр дахь удаагаа унавал шууд хасагддаг.

Франц

Дараагийн удаад Францын "National Gendarmerie Intervention Group" буюу GIGN бүлгийг нэрлэж болох юм. Тэдний эрхэм зорилго нь терроризмтой тэмцэх, барьцаалагсадыг аврах, үндэсний аюулгүй байдлын заналхийллийг хянах, төрийн өндөр албан хаагчдыг хамгаалах, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх зэрэг болно.

GIGN тусгай хүчинд элсэхийн тулд нэг долоо хоногийн урьдчилсан сонгон шалгаруулалтад оролцох ёстой. Үүнд эрүүл мэнд, намтар, гэр бүлийн байдал, биеийн тамир, ярилцлага зэрэг сорил багтана. Дараа нь сонгогдсон хүмүүст 14 сарын хугацаатай сургалтыг санал болгодог. Тус сургалтаар буудлагын бүх төрлийн арга, тэр дундаа мэргэн буудлага (энэ нь дэлхийн хамгийн шилдэг мэргэн буудагчийн дамжаанд тооцогддог) багтана. Мөн гардан тулааны бэлтгэл, IQ, сахилга

бат, биеийн хүч, сэтгэл зүйн бэлтгэлээс бүрдэнэ. Шалгуур өндөртэй тул сонсогчид эхний шатанд стресст орж, сэтгэл зүйн тогтворгүй байдалд орох нь элбэг. Тиймээс нийт элсэгчдийн зөвхөн 7-8 хувь нь сургалтын бүх үйл явцыг амжилттай давж гардаг.

Сургалтын хөтөлбөрт төрөл бүрийн зэвсэгтэй харьцах, "HALO" шүхрийн үсрэлт, нисдэг тэрэгнээс үсрэх, усны гүнд тусгай хэрэгсэлтэй шумбах, байлдах, усан онгоц руу довтлох, нууц хяналт явуулах, мөрдлөг хийх, зугтах арга техникүүд, гар хийцийн тэсрэх бөмбөгийг таних, устгах, саармагжуулах, халуун ширэнгэн ой, цөл, цавчим уулс, тэсгэм хүйтэн орчинд амьд үлдэх, байлдааны ажиллагаа явуулах, хэлэлцээр хийх гэх мэт байлдааны ажиллагаанаас дипломат ур чадвар хүртэлх маш олон төрлийн боловсролыг тухайн сонсогчдод олгогдоороо онцлог юм.

ОХУ

ОХУ-ын Тусгай хүчний Спецназ хэмээн нэрлэдэг. Тэд өөрийн берет малгайгаараа ялгарах ба Хуурай замын цэрэг, Агаар-Сансрын цэрэг нь цэнхэр берет, Тэнгисийн цэрэг, Тэнгисийн явган цэрэг нь хар берет, Үндэсний хамгаалалт албаны Тусгай хүчин нь хүрэн улаан берет малгай өмсдөг. Спецназад элсэхийн тулд 28 наснаас доош, 175 см-ээс дээш өндөртэй байх ёстой. Элсэхийн тулд долоон үндсэн шалгалтаас бүрдсэн биеийн тамирын өндөр шалгуурыг давах болдог. Хамгийн сонирхолтой шалгалт нь, худлаа ярьж буй эсэхийг тогтоох шалгуур юм.

Жилд хоёр удаа сонгон шалгаруулалт явагдана. Сонсогчид нь үндсэн сургалтын хугацаанд өдөрт 20 цаг хичээллэж, дөрвөн цаг унтаж амардаг. Өглөө 6 цагаас босч, гүйлт, гимнастикийн дасгал, гардан тулаан, цэрэгжлийн спортын дасгалыг гүйцэтгэнэ. Хэрэв тэд хүнд бэлтгэлийн ачааллыг давж чадахгүй бол курсээс хасагддаг. Үндсэн сургалтад зэвсэгтэй харьцах, мэргэн буудлага, хурдан буудлага, олсны хичээл, хананд авиралт, шүхэр, анти-терроризм, усанд сэлэлт, эмнэлгийн тусламж зэрэг 20 гаруй хичээл багтдаг.

Үндсэн шалгаруулалтыг нийт элсэгчдийн дунджаар 20 хувь нь давж гардаг гэсэн судалгаа байдаг. Тэдгээр сонсогчид бэлтгэлийн төгсгөлд хүрэхэд цэрэгжлийн спортын мастер цол тэмдгийн болзлыг шууд хангасан байдаг аж.

Спецназын бүтэц доторх Альфа багт үүрэг гүйцэтгэхэд үүнээс ч хүнд шалгуурыг давах болдог. Шалгуурын талаарх мэдээлэл одоо ч нууц хэвээр. Тодорхой бус эх сурвалжийн мэдээллээс үзвэл, 7-8 хоног ширэнгэн ойд хоолгүй явах, унтаж амраахгүй олон хоног үүрэг гүйцэтгүүлэх зэргээр сэтгэл зүй, тэсвэрийн сорилыг авдаг. Зөвхөн энэ шалгуурын үеэр гэхэд элсэгчдийн 50 хувь нь хасагддаг. Мөн 10 кг-ийн ачаатай 10 км газрыг нэг цагийн дотор туулах, 40 кг ачаатай 65-70 км газар маш гүйлх зэрэг шалгаруулалт байдаг гэдэг.

Энэхүү мэдээлэл нь дэлхийн хамгийн шилдэг гэгдэх тусгай хүчинтэй улсуудын сургалт, бэлтгэлийн зөвхөн ил болсон мэдээллүүдийн нэгээхэн хэсэг юм. Тусгай цалин хангамж, хувцас хэрэглэл эдэлж, энэ хэрээрээ тусгай зэвсэг агсаж, тусгай даалгавар биелүүлэхийн тулд тэд ийм хүнд замыг туулдаг аж.

Израиль



Израиль Улсын Саярат Маткал "Sayeret Matkal" Тусгай хүчний тус улсын Зэвсэгт хүчний Ерөнхий штабын тагнуулын алба хариуцаж ажилладаг. Тус тусгай хүчин нь тактикаас стратегийн түвшин хүртэл тагнуулын ажиллагаа явуулах, чухал мэдээллийг олзворлох, дайсны ар талд хорлон сүйтгэх ажиллагаа зохион байгуулах, терроризмтой тэмцэх, Израилийн нутаг дэвсгэр болон хилийн чанадад барьцаалагдсан хүмүүсийг аврах ажиллагаа явуулах үндсэн чиг үүрэгтэй. Энэхүү хүчин нь "Хэн зориглож чадна, тэр ялан дийлнэ" уриатайгаар 1957 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа юм.

Элсэхийн тулд Израильд төрсөн, бие бялдар жигд, эрүүл мэнд сайтай, оюун ухааны сорилд хамрагдах ёстой. Тэнцвэл тав хоногийн чиг баримжаа олгох сургалтад хамрагддаг. Сургалт

нь 16 сар орчим үргэлжилдэг, сонсогчдыг жинхэнэ Тусгай хүчний бэлтгэгдсэн цэрэг болгон хувиргадаг аж. Тусгай хүчинд элсэхэд биеийн тамирын шалгуур үзүүлэлт нь бусад төрлийн цэрэгт элсэхээс хавьгүй өндөр шалгууртай. Ачаатайгаар сууж босох, 60 кг-ийн хүнд хайрцаг түрэх, төмөр бөмбөг шидэх зэрэг дасгалыг нормативын дагуу биелүүлэх үүрэгтэй. Манай биеийн тамирын шалгуур үзүүлэлтэй ойр нь 3300 м-ийн гүйлт бөгөөд хамгийн бага хугацаа нь 14 минут байна. 11.5 минутын дотор гүйвэл болзоллоо хангадаг. Сонсогч бүрийн хувь заяаг шийддэг шалгалт нь "Ем Саярот" юм. Энэ нь сонсогчид элсэн манхан руу олон удаа гүйдэг сорил юм. Элсэн манхны оройд байрлуулсан цэгт сум, галт хэрэглэл бусад ачааг багийн хамтаар богино хугацаанд гаргах ёстой. Үүгээр сонсогчдыг багаар

хэрхэн ажиллах чадвартай болохыг шалгадаг. Их хэмжээний ачааг элсэн манхан дээр гаргахын тулд багаараа нүх ухаж, унтах майхнаа барьж, ээлжээр ачаагаа түрж, амралтаа зохицуулах, бэлэн байдлаа хадгалах зэрэг олон талын сорилтод ордог. Уг даалгавар нь бие бялдрын хөгжил-чийрэгжилт чухал юм шиг боловч гол шийдвэрлэх хүчин зүйл биш. Үүний оронд сэтгэл зүйн хат, тэсвэр тэвчээр, тууштай байдал, багаар ажиллах чадвар чухалд тооцогддог.

Дараагийн шатанд сонсогчид байр зүйн хичээл, хутгатай болон хутгагүй гардан тулааны бэлтгэл, мэргэн буудлагын таван үе шаттай сургалтыг дуусгаад, дэвшилтэт технологийн сургалт, усанд сэлэх, шумбан байлдах сургалтад хамрагдана. Гэхдээ сургалтын туршид сонсогчоос зөвхөн үр дүн харахгүй. Тэдний хандлага, манлайлал, сэтгэн бодох чадвар, багаар ажиллах чадварыг харгалзан үздэг. Нийт 16 сарын хугацаатай сургалтад хамрагдсаны дараа тэднийг таван сарын турш нарийн мэргэжлийн курсэд хамруулдаг. Сургалт ангилсан байдлаар явагддаг тул одоо хүртэл олон нийтэд мэдээлэл нь нууц байсаар иржээ. Сайерет Маткалын дэлхий даяар явуулж буй үйл ажиллагаа нь нууцлалын маш өндөр түвшинд явагддаг. Тагнуулын маш өндөр чадвартай бүрэлдэхүүнээр эгнээгээ зузаатгадаг гэдгээрээ бусад Тусгай хүчний цэргээс эрс ялгардаг.

ЭР ЦЭРЭГ-ЭХ ОРНЫ ЦЭРЭГ

Хоёрдугаар сард таныг юу хүлээж байна вэ

>Их Жанжин Д.Сүхбаатарын мэндэлсэн өдөр. МАН-ыг үүсгэн байгуулагчдын нэг тэрээр Ардын цэргийн анхны жанжин, Ардын Засгийн газрын анхны Цэргийн яамны сайд, бүх цэргийн жанжин юм.

>Батлан хамгаалах, Зөвсөгт хүчний төв хэвлэл "Соёмбо" сонин 97 жилийн ой. Тус сонин нь Цэргийн салбарын анхны сонин "Ардын цэрэг" нэртэйгээр 1924 оны 2 дугаар сарын 5-нд хэвлэгдсэн бөгөөд 1997 оноос "Соёмбо" нэрээр уншигчдын гарт хүрч эхэлсэн юм.

>Гэгээн Валентины баяр. Уг баярыг Европ тивд XIII зуунаас эхлэн тэмдэглэгдэж ирсэн.

>Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3. Сар шинийн баярыг бүх нийтээр тэмдэглэн өнгөрүүлэхээр хуульчилсан.

>Хувь хүний орлогын албан татварын хуулинд заасны дагуу Орон сууцны болон Сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах боломжтой.



Гэрэл зургийг ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ

СУМЛАТЧ БААВГАЙ ВОЕТЕК

Дэлхийн түүхэнд өөрийн гавьяагаараа нэр алдраа мөнхөд дуурсгасан баатарлаг амьтан цөөнгүй. Үүнд сансрын шинжлэх ухаанд эргэлт хийсэн Лайка нохой, хиймэл эсийн хуваагдлаар мэндэлсэн Долли хонь зэргийг нэрлэж болох юм. Тэр дундаас Польш түмний дунд ам дамжин яригддаг 300 гаруй кг жинтэй хүрэн баавгай Воетекийг онцлоё. Түүний нэрийг польш хэлнээс хөрвүүлбэл "Тулалдахын төлөө төрсөн нэгэн" гэх утгатай аж. Воетек баавгай нь дэлхийн хоёрдугаар дайны үед польш цэргүүдийн итгэл найдвар, гэрэл гэгээ нь болсон юм.

1942 оны 7 дугаар сарын 1-нд их бууны 22 дугаар салааны цэргүүд Ираны Хамадан хэмээх галт тэрэгний өртөөний дэргэдүүр эргүүл хийх үедээ нэгэн жаал хүү бяцхан бамбаруушийг дагуулан ихэд гутарсан царайтай явж байхтай таарчээ. Тэд хүүтэй ярилцаж үзэхэд уг бамбаруушны "эцэг эх"-ийг анчид буудсан болохыг олж мэдсэн байна. Цэргүүд тэр хоёрыг ихэд өрөвдсөн тул хүүд хоол хүнс өгч, бамбаруушийг нь өөрсдөө тэжээхээр болжээ. Ийнхүү бяцхан бамбарууш хувь тавилангийн эрхээр зэр зэвсэг агссан олон цэрэгтэй хамт амьдрах болов. Дайны үеэр бяцхан бамбарууш их бууны чанга дуунаас ихэд айж цочдог байсан тул шөнө болох үед цэргүүдийн өвөрт ээлжлэн орж унтдаг байсан гэдэг. Эрчүүд архи, шар айраг уусан шилэндээ сүү найруулж, бяцхан бамбаруушийг угждаг байжээ. Удалгүй 1943 оны зун гэхэд өнөөх бамбарууш өсөж томрон нас бие гүйцсэн том баавгай болов.

Баяр ёслол, найр наадам дээр ч Воетек үргэлж тэдэнтэй хамт байх болов. Эрчүүд л хойно заримдаа архи дарс хэрэглэх нь тодорхой.



Баавгай ч шар айраг уух дуртай байж. Цаг хугацаа өнгөрөхөд баавгай өөрийн мэдэлгүй их бууны 22 дугаар ангийн нэгэн "албан хаагч" болов. Тэрээр Ойрхи Дорнодын хэд

хэдэн тулалдаанд оролцон, их бууны сум зөөж цэргүүдэд тусалсан аж. Том биетэй хүчирхэг баавгай олон сумыг нэг зэрэг зөөн ангийнхандаа ахан дүүстээ маш том тус хүргэж, ялалт байгуулахад үнэлж баршгүй хувь нэмэр оруулжээ. Энэ үеэр польш цэргүүд баавгайн байгуулсан гавьяаг үнэлж түрүүч цол олгосон байна.

Дэлхийн хоёрдугаар дайн албан ёсоор дуусах, германчууд ялагдал хүлээж үг дуугүй бууж өгөх тогтоолд гарын үсэг зурав. Холбоотны тал дайн дууссаны баяраа тэмдэглэхийн хажуугаар Воетек ч гэсэн тэдэнтэй нэгджээ. Ингэхдээ долоо хоног шар айраг ууж, тамхи татаж баяраа тэмдэглэсэн байна. Гэвч Польшийн төр засаг социалист бодлогоор замнах болсон тул их бууны 22 дугаар



ангийн цэргүүд Европын бусад улс орнуудад цагаачлан амьдрахаар хэд хэдэн хэсэг болон тарж одов. Ганцаараа үлдсэн хөөрхий баавгайд очих газаргүй тул цэргүүд дээд удирдлагуудтайгаа ярилцаж байгаад Шотландад амьдардаг Санвик хэмээх нэгэн хөгшин фермерт үрчлүүлжээ.

1963 оны 12 дугаар сарын 2-нд Воетек 21 настайдаа өөд болсон юм. Олон жилийн дараа буюу 2013 онд Краков хотын Зөвлөлийн нийтийн хуралдаанаар Монте Кассиногийн байлдааны 70 жилийн ойн өдрөөр эрэлхэг зоригт түрүүч Воетек баавгайн дүрийг хөшөө болгон мөнхөлжээ. Мөн Их Британийн Эдинбург хотын Зөвлөл домогт баавгайн хөшөөг 2015 онд Хунтайжийн гудамжны цэцэрлэгт хүрээлэнд босгосон түүхтэй.

Воетек баавгайн гайхамшигт баатарлаг үйл хэргийг өнөөдөр ч польшууд ам дамжин ярьсаар байдаг.

Үндэсний бахархал,

ӨВ СОЁЛ

Сүхбаатарын
мэндэлсэн өдөр
Ман-ыг үүсгэн
байгуулагчдын нэг
тэрээр Ардын
цэргийн анхны
жанжин, Ардын
Засгийн газрын
анхны Цэргийн
яамны сайд,
бүх цэргийн
жанжин юм.

ҮЛГЭРТЭЙ ТАСГИЙН ДАРГА

Хошууч Эриндийн командлан ангийн тасгийн дарга Гочоогийн тасаг нь винтовын буудлага ба биеийн тамираар онц сайн шалгарч өөрийн ангийн даргаас үнэ бүхий зүйлээр шагнагджээ. Эл тасгийн буудлага нь сайн байдаг бөгөөд биеийн тамирт байлдагч бүхэн өөрийн нормийг хангалттайгаар дүүргэжээ. Бусад олон бага дарга нар энэхүү Гочоогийн тасгаас ба түүний ажлаас үлгэрийг авах хэрэгтэй хэмээн нийтэд нэгэн адил сануулъя.

Батлан хамгаалахын Төв архивын сан хөмрөгөөс "Улаан одон" сонин. 1937.04.20 Дугаар №16 /422/ хуудас-3

ЭМГЭНЭЛ

ГОМБЫН ДАМБАРАВЖАА (1923-2021)



Ахмад дайчин Онход овогт Гомбын Дамбаравжаа нь хүнд өвчний улмаас хорвоогийн мөнх бусыг үзүүлж бидэнд нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо.

Г.Дамбаравжаа 1923 оны 2 дугаар сарын 20-нд Хөвсгөл аймгийн Их-Уул сумын 7 дугаар багийн нутаг Хужирбулан хэмээх газар төрсөн. Бага насаа эцэг, эхийн гар дээр өнгөрүүлж, 11 насандаа сумын "Сайн дурын бага сургууль" /гэр/-д суун уйгаржин монгол бичиг, дөрвөн аргын тоо заалгаж бичиг үсэгтэй болсон.

Улмаар 20 нас хүртлээ мал маллаж байгаад 1943 онд хугацаат цэргийн албанд татагдан Сүхбаатар аймгийн Дарьганга, хурандаа Гомбожавын 17 дугаар отрядын 11 дүгээр заставт алба хаан 1945 оны Чөлөөлөх дайнд оролцож байсан ахмад дайчин юм.

Тэрээр цэргээс халагдан Их-Уул сумын сүү тосны заводын мастераар ажиллаж байгаад 1952 онд УБ хотод Үйлдвэр хоршооллын ханган нийлүүлэх баазад нярав, хотын автобус баазад шугамын автобусны жолоочоор ажиллаж байсан. 1962 онд Хөвсгөл аймгийн Их-Уул суманд шилжин ирж, шинээр байгуулагдсан "Мал аж ахуйн машинт станц"-д жолооч, 1966 оноос Хөвсгөл аймгийн Эрүүлийг хамгаалах газар, Нэгдсэн эмнэлгийн түргэн тусламж, аймгийн "Төв эмийн сан"-д жолоочоор ажиллаж байгаад 1985 оноос өндөр насны чөлөөндөө гарсан аж.

Ахмад дайчин Г.Дамбаравжаа нь эх орныхоо тусгаар тогтнол, бүтээн байгуулалтад бүхий л амь бие, хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж байсан юм.

Талийгаачийн гавьяа зүтгэлийг төр, засгаас өндрөөр үнэлэн Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны одон, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль, Монгол Зөвлөлтийн "Бид ялав" медаль, Сталины медаль, Халхын голын байлдааны ялалтын 30, 80, Милитарист Японыг ялсны 30, Зөвсөгт хүчний 60, Жуковын 100, Их Монгол Улс байгуулагдсаны 800, Чөлөөлөх дайны ялалтын 65, 70, Эх орны дайны ялалтын 70, 75 жилийн ойн медалиудаар тус тус шагнасан юм.

Г.Дамбаравжаа нь эх орон, ард түмнийхээ тусгаар тогтнолын төлөө болон Эрүүл мэндийн энхийн манаанд хоёргүй сэтгэлээр зүтгэсэн эх оронч, залуу үеийг "Халамжлан хүмүүжүүлэгч", "Ахмад дайчин" хүн байсан.

Эрхэм таны эх оронч, залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч, хүнлэг энэрэнгүй, ажилч хичээнгүй, бүтээлч зан чанар бидний зүрх сэтгэлд үүрд хоногшин үлдэх болно.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УДИРДЛАГА, ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ, АХМАДЫН ХОРОО, ҮР ХҮҮХЭД, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД НЬ

Эрүүл зөв хооллолт гэж юу вэ?

Эрүүл хооллолт гэдэг нь чанга хатуу хоолны дэглэм барих, хэтэрхий туранхай байх, хоол хүнснийхээ хэрэглээг хязгаарлаж, дуртай зүйлээсээ татгалзана гэсэн үг биш юм. Харин хоол хүнсээ зөв сонгон, зохистой бэлтгэн хэрэглэж, түүгээрээ дамжуулан таатай мэдрэмж, эрч хүч авах явдал юм. Эрүүл хооллолт нь хоол хүнсээ зөв танин мэдэх, зөв хооллох, түүнийгээ дадал болгон суралцахаас эхлэх бөгөөд таны юу идэж байгаа төдийгүй ямар хэмжээгээр идэж байгаагаас ихээхэн шалтгаална. Хоол хүнсээ зөв сонгож, зохистойгоор хэрэглэх нь зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин зэрэг өвчнөөр өвдөх эрсдэлийг багасгахын зэрэгцээ сэтгэл санааны хямралд орохоос урьдчилан сэргийлж чадна. Үүний зэрэгцээ зөв хооллож сурснаар таны эрүүл мэнд, ой ухаан сайжирч, эрч хүч нэмэгдэж, сэтгэл санаа тань тогтворжино.



3. Хэрэглэж байгаа хоол хүнсний ихэнх хэсэг нь цардууллаг байхаас гадна эслэг агуулсан байх хэрэгтэй.
4. Төрөл бүрийн жимс жимсгэнэ, хүнсний ногоог түлхүү хэрэглэх.
5. Сүү, сүүн бүтээгдэхүүн, загасны мах, ногоон өнгний навчит ургамал зэрэг калыц ихээр агуулдаг бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэх.
6. Өөх тос, сахарын хэрэглээг хязгаарлах.
7. Давсыг багаар хэрэглэх.
8. Хөдөлгөөний хомсдол, илүүдэл жингүй байх
9. Ус ихээр хэрэглэх
10. Өглөөний цайг заавал ууж хэвших

Түргэн иддэг хүн амархан таргалдаг

Хоолыг сайтар ажлан, тайван идэж хэвших хэрэгтэй. Бүхэл мах зэргийг заавал жижиглэж идэх нь чухал. Бага багаар тайван идэхэд цадсан мэдрэмж амархан төрдөг. Ингэх нь ходоодны үйл ажиллагаанд тустай. Хоол иддэг аяганыхаа хэмжээг багасга. Болж өгвөл хоол нэмүүлэхгүй байхыг хичээ. Аажимдаа цаг наргүй иддэг зуршлаасаа сална. Ном сонин унших, зурагт үзэж байхдаа хоол иддэг муу зуршлаасаа татгалз. Элдэв амттаны оронд лууван юм уу нэг ширхэг алим иддэг байх нь таны биед тустай.

Цэргийн төв эмнэлгийн арьс харшлын сувилагч П.АДЪЯАТОГТОХ

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

Эхийг "Соёмбо" сонин
редакцад бэлтгэж,
"Соёмбо принтинг" хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029